Корпорацууд холбооны хүнд суртлын дарамт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар гомдоллож болох ч гэм буруутай компаниуд засгийн газартай заргалдах мэдлэг чадвар, боловсон хүчин, цаг хугацаа зарцуулах боломжтой байдаг. Хуулийн этгээдийн зөрчлийг шалгах агентлагууд хүчирхэг корпорацуудын эсрэг хууль хэрэгжүүлэх нь үр дүнгүй байна гэж шүүмжлэлийг их өрнүүлдэг. Ихэнхдээ хууль зөрчигчдөд хүлээлгэх шийтгэл нь түүний хууль бус үйлдлийг зогсоох, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх үүрэг гүйцэтгэхэд хэтэрхий бага байдаг. Цагаан захтнуудад ял оноох нь бага бөгөөд тэд шоронд хоригдох нь ховор байдаг. Томоохон хуулийн этгээдүүд өөрсдийн салбаруудын захирал болон хуулийн хэлтсийн даргаар урьд нь хуулийн этгээдүүдийг шалгах, зохицуулах агентлагуудад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан мэргэжилтнүүдийг ажилд авах сонирхолтой байдаг байна. Нэмж дурдахад засгийн газраас хуулийн этгээдийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэхэд хуваарилдаг мөнгөний хэмжээ нь гудамжны гэмт хэрэгтэй тэмцэхэд зориулагдсан мөнгөнөөс хамаагүй бага байдаг³⁵.

АНУ-ын Дээд шүүхийн 1886 оны шийдвэрээр Санта-Клара тойрогт, Номхон далайн өмнөд төмөр замын 118 АНУ 394 (1886) корпорацийг "этгээд /person/" гэж хууль ёсоор тодорхойлж болно гэж АНУ-ын янз бүрийн шүүхүүдэд мэдэгдсэн байдаг. АНУ-ын Үндсэн хуульд оруулсан арван дөрөв дэх нэмэлт өөрчлөлтөд энэ талаар дурьдсан байна.

Английн хуулинд үүнийг Salomon v Salomon & Co [1897] AC 22-ийн шийдвэрээр тохирчээ. Австралийн хуулиар 2001 оны корпорацуудын тухай хуулийн дагуу (Cth) корпорац нь хууль ёсоор "хуулийн этгээд /legal person/" гэсэн байдаг³⁶.

АНУ-ын хууль одоогоор корпорацын эрүүгийн хариуцлага хүлээх чадавхийг хүлээн зөвшөөрдөг. Францын хуулиар одоогоор компанийн эрүүгийн хариуцлага хүлээх чадавхийг хүлээн зөвшөөрдөг. Германы хууль нь корпорацын эрүүгийн хариуцлага хүлээх чадавхийг хүлээн зөвшөөрдөггүй. Герман улс нь корпорацуудад зөрчлийн шийтгэл оногдуулдаг³⁷. Компанийн буруутай үйл ажиллагааг зохицуулах олон улсын гэрээг ингэснээр зөвшөөрөх хандлагатай байдаг боловч корпорац эрүүгийн хариуцлага хүлээхгүй гэсэн зарчим үйлчилдэг байна.

Хууль сахиулах бодлого.

Корпорацын гэмт хэрэг зарим оронд төр засгийн хэмжээнд анхаардаг болсон. Жишээлбэл: Их Британид төмөр замын сүлжээ болон далайд гарсан осол аваарыг олон нийтэд корпорацын хүн амины хэрэг гэж нэрлэн хэрэглэгддэг бөгөөд бизнесийн аж ахуйн нэгжүүдэд учирдаг технологийн аюулын талаар илүү их хэлэлцүүлэг зохион байгуулдаг байна³⁸.

АНУ-д 2002 онд батлагдсан “Sarbanes-Oxley” хууль нь Enron, Worldcom, Freddie Mac, Lehman Brothers гэх мэт олон нийтийн дунд дуулиан шуугиан болсон

³⁵ [Frank E. Haqan](#)

³⁶ https://en.wikipedia.org/wiki/Corporate_crime

³⁷ (Ordnungswidrigkeiten)

³⁸ (see Wells: 2001)

бизнесийн үйл ажиллагаа, түүний дотор корпорацын хариуцлага, санхүүгийн ил тод байдал, луйвартай тэмцэх чиглэлээр шинэчлэгдсэн³⁹. Компанийн гүйцэтгэх захирал болон компанийн санхүүгийн захирал (CFO) нь санхүүгийн тайланг үнэн зөв, холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг биечлэн баталгаажуулах шаардлагатай бөгөөд үүнийг санаатайгаар буруу үйлдсэнийх нь төлөө эрүүгийн хариуцлага оногдуулж, мөнгөн торгууль 5000,000 доллар хүртэл, 20 жил хүртэл хорих ял оноох болсон байна⁴⁰.

Өмнөд Уэльсийн Хуулийн Шинэчлэлийн Хороо ийм гэмт хэргийн үйл ажиллагааны талаархи дараах тайлбарыг хийсэн байна. Үүнд:

Хуулийн этгээдийн гэмт хэрэг нь иргэдийн сайн сайхан байдалд ихээхэн аюул заналхийлж байна. Манай нийгэмд олон төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг корпорацууд байдаг бөгөөд тэдний үйл ажиллагааны нөлөөлөл нь хувь хүний үйл ажиллагаанаас илүү өргөн хүрээний хүмүүст нөлөөлдөг болохыг харгалзан үзвэл корпорацын учруулсан эдийн засгийн болон бие махбодид үзүүлэх хор хохирол нь маш их юм⁴¹.

Үүнтэй адил санааг Расселл Мохибер ба Роберт Вайсман (1999) нар дэвшүүлжээ. Тухайлбал: Нэг түвшинд корпорацууд шинэ технологи, эдийн засгийн цар хүрээг хөгжүүлдэг. Эдгээр нь шинэ бүтээгдэхүүн, массын үйлдвэрлэлийн илүү үр дүнтэй аргыг нэвтрүүлэх замаар массын хэрэглэгчдийн эдийн засгийн ашиг сонирхолд нийцэх боломжтой юм. Өөр түвшинд, өнөөдөр улс төрийн хяналт байхгүй бол корпорацууд нь иргэний нийгмийн үндэс суурийг болон тэдгээрийн оршин сууж буй хүмүүсийн амьдралыг устгахад үйлчилдэг...

Ашигласан материал:

"The Laws That Govern the Securities Industry". Retrieved 5 December 2016.

"Sarbanes-Oxley Act of 2002" (PDF). 107th Congress. Retrieved 5 December 2016. (Law Reform Commission of New South Wales: 2001)

Models of corporate criminal liability in comparative law. Washington university global studies law review vol.4

V.S.Khanna, Corporate Criminal Liability: What Purpose does it Serve, Har.L.Rev. 109 (1996)

Celia Wells, Corporations and Criminal Responsibility, page 85(Oxford University press 2nd ed. 2005)

ЦАХИМ ЭХ СУРВАЛЖ:

<https://www.britannica.com/topic/corporate-crime#ref336083>

https://en.wikipedia.org/wiki/Corporate_crime

³⁹ "The Laws That Govern the Securities Industry". Retrieved 5 December 2016.

⁴⁰ "Sarbanes-Oxley Act of 2002" (PDF). 107th Congress. Retrieved 5 December 2016.

⁴¹ Шинэ Өмнөд Уэльсийн Хуулийн шинэчлэлийн хороо: 2001 (Law Reform Commission of New South Wales: 2001)

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ**ЦАГДААГИЙН ХЭСГИЙН БАЙЦААГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ**

Докторант, цагдаагийн
дэд хурандаа Б.Баянмөнх
*Дотоод хэргийн их сургууль,
Монгол Улс Цахим шуудан:*
bayanmunkh@uia.gov.mn

Товчлол. Цагдаагийн алба хаагчийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ, тодорхой ажиллагааны арга, хэлбэр, арга зүйг хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актаар зохицуулагдаж байдаг. Энэхүү өгүүлэлд цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын талаар товч авч үзсэн болно.

Түлхүүр үг: хэсгийн байцаагч, хууль, заавар, албан тушаалын тодорхойлолт,

Үндсэн хэсэг. Цагдаагийн хэсгийн байцаагч нь цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлж, нийтээр дагаж мөрдөх хууль тогтоомжийг сахиулах олон талт үйл ажиллагааг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах үүрэгтэй цагдаагийн алба хаагч юм.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн албан тушаалын энэхүү олон талт чиг үүргийн онцлогтой уялдан түүний үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын хүрээг Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон тэдгээрт нийцсэн бусад хууль, дүрэм, журам, заавраар тодорхойлж байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн анхан шатны нэгж болох хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтээр дагаж мөрдөх хууль тогтоомжийн сахиулах чиг үүрэгтэй хороо хариуцсан хэсгийн байцаагчийн албан тушаалыг 1975 онд бий болгосноос хойш 1993 он хүртэлх хугацаанд БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчид болон Сайд нарын Зөвлөлөөс баталсан Цагдан сэргийлэх байгууллагын тухай дүрмүүдээр үйл ажиллагааг нь зохицуулж иржээ.

1993 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас Цагдаагийн байгууллагын тухай хуулийг баталж, 1994 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр цагдаагийн байгууллага, алба хаагч хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нөхцөл анх удаа бүрдсэн байна.

Цагдаагийн байгууллагын тухай хуульд заасан үүргийн хүрээнд хэсгийн байцаагч нь хариуцсан хорооны нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцлийг тогтоож арилгах ажлын хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдэл өгч, түүний хэрэгжилтийг хангаж ажиллах, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдэж байгаа тухай мэдээллийг

авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх шуурхай арга хэмжээ авах, нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагатай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хорих ял эдлээд суллагдсан хүнд захиргааны хяналт тавих, гудамж талбай, олон нийтийн газар нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг сахиулах эргүүл хийх, хариуцсан нутаг дэвсгэрийн объектын судалгаа хийх, хуулиар харъяалуулсан захиргааны зөрчлийг шалгаж шийдвэрлэх зэрэг олон талт үйл ажиллагаа явуулж байлаа.

Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн 2013 он хүртэл хугацаанд цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааг Цагдаагийн байгууллагын тухай хуулиас гадна бусад 17 хууль, Засгийн газрын тогтоолоор батлагдсан 2 дүрэм, 1 хөтөлбөр, тогтоол 1, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлагдсан 2 журам, 4 дүрэм, ЦЕГ-ын даргын тушаалаар батлагдсан 8 заавар, 1 дүрэм, 13 журмаар зохицуулж байжээ.

ЦЕГ-ын даргын 2003 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 229 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ыг баталсан нь олон хууль, эрх зүйн актаар зохицуулагдаж байсан тухайн албан тушаалын эрх хэмжээ, алба хаагчийн субьектив эрх, хууль зүйн үүргийг нэгтгэн эрэмбэлж, тусгайлан зааварчилсан чухал ач холбогдолтой шийдвэр байсан бөгөөд өнөөг хүртэл мөрдөн ажиллаж байна.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны чиглэл, эрх зүйн байдлыг тодорхойлж буй өнөөгийн эрх зүйн зохицуулалтын хүрээг хууль зүйн хүчин чадлын хувьд дараах байдлаар ангилан авч үзлээ. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хуулийн зохицуулалт;
- Цагдаагийн албаны тухай болон бусад хуулийн зохицуулалт;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор баталсан дүрэм, журам, бодлогын баримт;
- Монгол Улсын сайд, агентлагийн даргын тушаалаар баталсан дүрэм, журам, заавар;
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамжаар баталсан журам, захиргааны актын хүрээнд тус тус авч үзье.

Монгол Улсын Үндсэн хуулийн зохицуулалт: Монгол Улсын Үндсэн хууль бол монголын ард түмний эрхэм зорилго, нийтлэг хүсэл зоригийн илэрхийлэл болсон гол тулгуур хууль болохын хувьд Монгол Улсын нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын харилцааны эрх зүйн үндсийг тодорхойлсон. Үндсэн хуулийн удиртгал хэсэгт тунхагласан Монголын ард түмний эрхэм зорилго нь Монгол Улсын эрх зүйн тогтолцооны үндсэн зорилгыг илэрхийлж, нийгмийн харилцааг зохицуулах зориулалтыг тодорхойлж байдаг. Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлд “...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.”, 19 дүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан

нь төрөөс иргэнийхээ өмнө хүлээсэн үүргийн илэрхийлэл төдийгүй цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлсон Үндсэн хуулийн зохицуулалт мөн. Мөн Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх...”⁴² гэж хуульчилсан явдал нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд баримтлах үзэл баримтлалын үндсэн чиглэл юм.

Цагдаагийн хэсгийн байцаагч төрөөс иргэнийхээ өмнө хүлээсэн цагдаагийн байгууллагад хамаарах үүргийг биелүүлж, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг чанд сахин хэрэгжүүлэх явдал нь түүний эрх зүйн байдал, хууль зүйн үүргийн онцлогийг илэрхийлнэ.

Түүнчлэн Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн 14.1, 14.2, 16.12, 16.13, 16.14, 16.6, 16.17, 16.18, 19.3 дэх заалтуудыг үйл ажиллагааны эрх зүйн үндсэн эх сурвалжаа болгож байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн дээрхи бүх заалтууд нь цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны үндсэн эх сурвалж болох төдийгүй оролцож буй бүхий л ажил арга хэмжээнд мөрдөх эрх зүйн үндэс болж байна.

Үндсэн хуулийн 14.1, 14.2 дахь заалтууд нь хэсгийн байцаагчийн албан үүргийн хувиар харилцаж байгаа бүхий л субъектүүдтэй харилцаа үүсгэх үед баримтлах зарчим юм байна. Харин 16.2, 16.12, 16.4 заалтууд нь иргэний зөрчигдсөн эрхээ сэргээн хангахтай холбоотой үйл ажиллагаанд баримтлах бол 16.13, 16.16, 16.18, 18.5 дахь заалтыг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн иргэнийг шалгах явцад зарим эрхийг хязгаарлах, үйл ажиллагаа явуулах эрхэд тодорхой хэмжээний хязгаарлалт тогтоох үед, 25.2.1, 25.2.2 дахь заалтуудыг олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үед тус тус баримталж ажилладаг тул хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн үндсэн эх сурвалжид орж байна.

Иргэнээс гэмт хэрэг, зөрчилд холбогдох, эсхүл гэмт хэрэг, зөрчлийн улмаас зөрчигдсөн эрхээ сэргээн хангуулахтай холбоотойгоор Үндсэн хуулийн дараах заалтуудыг эрх зүйн эх сурвалж болгодог. Тухайлбал, 16.12. “Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй”, 16.13. “Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй”, 16.14. “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй”, 16.16. “Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно”, 16.17. “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй

⁴² Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль

асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй”, 16.18. “Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй”⁴³ гэсэн заалтууд юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд Үндсэн хуулийн 18.5-д заасныг баримтлан зохих хязгаарлалтыг хийж байгаа нь хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны нэг чухал зохицуулалт, нөгөө талаараа нийтийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн нэг үндсэн эх сурвалж болж байна.

Дээрхи бүгдийг нэгтгэн авч үзвэл цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулж, шудрага, хууль ёсны болон хүний эрхийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээнд нийцсэн зохицуулалтаар явагдаж байна гэсэн гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.

Цагдаагийн албаны тухай болон бусад хуулийн зохицуулалт: Цагдаагийн хэсгийн байцаагч нь Цагдаагийн албаны тухай хуулийн 5.1. “Цагдаагийн алба, алба хаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас гадна хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж, дэмжлэг авах, үйл ажиллагаа нь тасралтгүй байх, улс төрөөс ангид байх, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх....”⁴⁴ гэсэн зарчмыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж гэж ангилан авч үзээд хуульд заасан гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, захиргааны хяналтын чиг үүрэг гэсэн дөрвөн хэсэгт бүлэглэн авч үзлээ. Үүнд:

Цагдаагийн албаны тухай хуулийн зохицуулалт:

Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд: Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйл /Гэмт хэрэгтэй тэмцэх/-ийн 10.1.1-10.1.3, 10.1.7, 10.1.10, 38 дугаар зүйл /Эрэн сурвалжлах ажиллагаа/-ийн 38.1, 38.3, 38.4, 39 дүгээр зүйл /Мэдээллийг төлбөртэй авах/-ийн 39.1, 61 дүгээр зүйл /Үйл ажиллагаандаа тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сүлжээ, сан үүсгэж ашиглах/-ийн 61.1, 61.8⁴⁵ зэрэг нийт дөрвөн зүйлийн 11 заалт нь хэсгийн байцаагчаас гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн нэг эх сурвалж болж байна. Дээрхи зүйл заалтууд нь цагдаагийн хэсгийн байцаагчаас гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр явуулах дараах харилцааг зохицуулж байна. Үүнд: гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгуулах, гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах, таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авах,

⁴³ Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль.

⁴⁴ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

⁴⁵ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

гэмт хэргийн газрыг хамгаалах, нотлох баримт цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэмт хэрэг үйлдсэнд сэрдэгдсэн хүнийг эрэн сурвалжлах, баривчлах, гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт шийтгүүлсэн этгээдийн нэгдсэн тоо бүртгэл хөглөхтэй холбоотой харилцаанууд хамаарч байна.

Нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийн хүрээнд: Цагдаагийн хэсгийн байцаагчаас Цагдаагийн албаны тухай хуульд заасан нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцаа нь Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2, 11.1.4-11.1.8, 46 дугаар зүйлийн 46.1-46.7, 63 дугаар зүйлийн 63.11, 64 дүгээр зүйлийн 64.3, 64.4, 65 дугаар зүйлийн 65.1, 65.2, 65.5⁴⁶ зэрэг нийт таван зүйл, 20 заалтуудаар зохицуулагдаж байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн дээр зүйл, заалтуудаар цагдаагийн хэсгийн байцаагчаас нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийн хүрээнд зөрчлийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авах, хуулиар харьяалуулсан зөрчлийг шалгаж шийдвэрлэх, байгууллага, алба хаагчийг мэдээллээр хангах, гудамж, талбай болон нийтийн эзэмшлийн бусад газарт эргүүл хийх, техник хэрэгсэл ашиглан хяналт тавих, насанд хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, тэдгээрийг гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдэд шаардлага, сэрэмжлүүлэг өгөх, биелэлтийг нь хангуулах, хамтран ажиллах, олон нийтийн цагдааг мэргэжил, арга зүйгээр хангахтай холбоотой харилцааг зохицуулж байна.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд: Цагдаагийн хэсгийн байцаагч нь Цагдаагийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-12.1.3, 12.1.6, 12.1.7-д заасан чиг үүргүүд нь хэсгийн байцаагчаас олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлийн үйл ажиллагаа явуулах, оролцох эрх зүйн үндсийг тодорхойлж байна. Харин олон нийтийн аюулгүй байдлыг хангах тодорхой ажил, арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хамтран оролцох үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт нь Цагдаагийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2, 41 дүгээр зүйлийн 41.3, 43 дугаар зүйлийн 43.1, 44 дүгээр зүйлийн 44.1-44.3, 45 дугаар зүйлийн 45.1, 45.2⁴⁷ зэрэг 5 зүйлийн 8 заалтаар тодорхойлогдож байна.

Дээрхи зохицуулалтаар цагдаагийн хэсгийн байцаагчаас хариуцсан нутаг дэвсгэр дээр бүлэг хүмүүсийг тараах, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох, жагсаал, цуглааныг албадан тараах, нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, гамшгийн үед хорио цээрийн дэглэм сахиулахтай холбоотой үйл ажиллагаануудад оролцох эрх зүйн үндэс тодорхойлогдож байна.

Захиргааны хяналт тавих үүргийн хүрээнд: Цагдаагийн албаны тухай хуулийн 13-р зүйлийн 13.1.4, 13.1.5, 13.1.6⁴⁸ зэрэг нийт нэг зүйлийн гурван зүйл

⁴⁶ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль.

⁴⁷ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль.

⁴⁸ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль.

заалтуудаар цагдаагийн хэсгийн байцаагчаас захиргааны хяналт тавих үйл ажиллагааны эрх зүйн эх сурвалж болж байна.

Хэсгийн байцаагчаас явуулах бусад харилцааны эрх зүйн зохицуулалтын хүрээнд: Цагдаагийн хэсгийн байцаагч нь нутгийн захиргааны болон өөрөө удирдах байргууллагатай харилцахдаа Цагдаагийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйл /Засгийн газар болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас цагдаагийн байгууллагатай харилцах/-ийн 16.4, 16.5, иргэний зөвлөлтэй харилцахдаа 62 дугаар зүйл /Иргэний зөвлөл/-ийн 62.5, 62.6.3-62.6.6, олон нийтийн цагдаатай харилцах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангахдаа 63 дугаар зүйл /Олон нийтийн цагдаа/-ийн 63.5 – 63.7, иргэн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, тэдний дэмжлэг туслалцааг авахдаа 64.1-64.5, 65.2, 65.4, 65.5, албаны шуурхай байдлыг хангахдаа 59.1.1-59.1.5 зэрэг нийт таван зүйл, 22 заалтуудыг тус тус эрх зүйн эх сурвалжаа болгож байна.

Бусад хуулийн зохицуулалт:

Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд: Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2, 9.2.4, 10 дугаар зүйлийн 10.2.1, 10.2.2, 10.2.6, 10.2.7, 16 дугаар зүйлийн 16.1.3, 18 дугаар зүйлийн 18.2.8, 23 дугаар зүйлийн 23.2.1, 29 дүгээр зүйлийн 29.1.2, 29.1.3, 29.1.4, 29.1.8, 30 дугаар зүйлийн 30.2, 31 дүгээр зүйлийн 31.1-31.9, 33 дугаар зүйлийн 33.1.1-33.1.7, 35 дугаар зүйлийн 35.1-35.3, 36 дугаар зүйлийн 36.1, 36.2.4, 36.2.5⁴⁹ зэрэг нийт 11 зүйлийн 32 заалтууд нь хэсгийн байцаагчаас гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын чиглэл, зарим арга, хэлбэр, харилцааг зохицуулсан үйл ажиллагааны эрх зүйн эх сурвалж болж байна. Зохицуулсан харилцааны агуулгыг багцлан авч үзвэл:

- тодорхой этгээд гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор түүний зан үйл, ёс суртахуунд нөлөөлөх, гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй шалтгаан, нөхцөлийг арилгахад чиглэсэн арга хэмжээ авах;
- хүн, хуулийн этгээдийг гэмт халдлагаас хамгаалах, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нөлөөллийн соён гэгээрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран ажиллах, иргэн, хуулийн этгээдийг өмчийн хэлбэр харгалзахгүй татан оролцуулах;
- гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг илрүүлэх, дүн шинжилгээ хийх, түүнийг арилгах, гэмт хэрэг, зөрчлийн талаар тоо бүртгэл хөтлөх, цахим мэдээллийн сан бүрдүүлж ашиглах, мэдээллийг төлбөртэй авах;
- иргэн, хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан санал, санаачилгыг дэмжих, тэдний хүлээх үүрэгтэй холбоотой харилцааг зохицуулж байна.

⁴⁹ Төрийн мэдээлэл. 2019. №42. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 23 дугаар зүйлийн 23.1.1⁵⁰ зэрэг хоёр зүйлийн хоёр заалтуудаар цагдаагийн хэсгийн байцаагчаас гэмт хэрэг, зөрчлийн гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор биечилсэн хамгаалалтад авах үйл ажиллагааны эрх зүйн үндэс тодорхойлогдож байна.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1⁵¹ дэх заалт нь мал бүхий өрх амьдардаг хороодын хэсгийн байцаагч нараас мал хулгайлах гэмт хэргийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авахтай холбоотой харилцааг зохицуулж байгаа нь гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгт хамаарч байна.

Дээрхи гурван хуулийн 17 зүйлийн 46 заалт нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ болон зарим тодорхой ажил, арга хэмжээний арга зүйн үндсийг тодорхойлж өгсөн эрх зүйн зохицуулалт болж байна. Эдгээр хуулиудын зүйл, заалтууд нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж байгаа бөгөөд практикт зөрчилдөөн үүсгэх эсхүл хэрэгжих боломжгүй зүйл, заалт байхгүй байна гэж үзэж байна.

Нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийн хүрээнд: Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.7. “тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг, эсхүл үйлдэгдэж болзошгүй газар нутаг, үйл ажиллагаа, харилцаанд чиглэсэн цогц арга хэмжээг авах”, 8.2.8. “гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг болон үйлдэгдэж болзошгүй газар нутагт урьдчилан сэргийлэх эргүүлийн үйл ажиллагааг тогтмол хийх”⁵² гэсэн хоёр зүйлийн хоёр заалтууд нь Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой зүйл, заалтуудтай агуулгын хувьд нийцэж, хэсгийн байцаагчаас хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх эргүүл, хяналт шалгалт явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2.2-20.2.6, 23 дугаар зүйлийн 23.1- 23.7, 25 дугаар зүйлийн 25.1-25.7, 30 дугаар зүйлийн 30.1, 30.3-30.10, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2, 33 дугаар зүйлийн 33.6, 44 дүгээр зүйлийн 44.4⁵³ зэрэг нийт 7 зүйлийн 32 заалтаар цагдаагийн хэсгийн байцаагчаас гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт тодорхойлогдож байна.

Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 22.1⁵⁴ зэрэг нэг зүйлийн гурван заалтууд цагдаагийн хэсгийн байцаагчаас харуул хамгаалалтын үйл ажиллагаанд хяналт тавих, үйл ажиллагааг нь зогсоох, хариуцлага

⁵⁰ Төрийн мэдээлэл. 2013. №30. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль

⁵¹ Төрийн мэдээлэл. 2004. №23. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль

⁵² Төрийн мэдээлэл. 2019. №42. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

⁵³ Төрийн мэдээлэл. 2017. №5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

⁵⁴ Төрийн мэдээлэл. 2000. №4. Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль.

хүлээлгэхтэй холбоотой ажил, арга хэмжээний эрх зүйн зохицуулалтын эх сурвалж болж байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.12, 29 дүгээр зүйлийн 29.1.6. в, 30 дугаар зүйлийн 30.1.6, 39 дүгээр зүйлийн 39.1⁵⁵ зэрэг дөрвөн зүйлийн дөрвөн заалтаар Цагдаагийн хэсгийн байцаагчаас баг, хороо, сум, дүүргийн Засаг даргатай хамтран харьяалах захиргааны журмын биелэлтэд хяналт тавих, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, энэ ажилд иргэдийг татан оролцуулах, санал, санаачилгыг нь дэмжих үйл ажиллагаа зохицуулагдаж байна.

Цагдаагийн хэсгийн байцаагч нь нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон дараахи нийтийн хэв журмын зөрчлийг шалган шийдвэрлэж байна. Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 5.3 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.5, 5.6, 5.7, 5.8 дугаар зүйл, 5.9 дүгээр зүйл, 5.16, 5.19 дүгээр зүйл, 6.3 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 6.5 дугаар зүйлийн 1, 4, 5, 11, 12, 13, 15, 16 дахь хэсэг, 6.18 дугаар зүйлийн 4, 7 дахь хэсэг, 6.20 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 6.22, 8.8, 10.4, 10.26, 13.5, 15.1 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.10, 15.11, 15.20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.21 дүгээр зүйл⁵⁶ зэрэг нийт 24 зүйлийн 61 хэсэгт заасан зөрчлийг цагдаагийн хэсгийн байцаагч хянан шалгаж, шийдвэрлэж байна.

Энэ нь цагдаагийн хэсгийн байцаагчаас нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр гаргасан олон хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтэнд хяналт тавьж, зөрчигдсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэж байгааг харж болохоор байна. Нөгөө талаараа хэсгийн байцаагчийн шалган шийдвэрлэж байгаа дээрхи зөрчлийн харьяалах хязгаарыг тогтоож өгөхгүй бол гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ зохион байгуулж явуулах, хэв журам сахиулах эргүүл хийх цаг бага гарч, хариуцсан нутаг дэвсгэртээ нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагаа явуулах боломжийг бууруулах нэг хүчин зүйл болж байна. Үүнийг цаашид анхаарч, хэсгийн байцаагчийн харьяалан шалгах зөрчлийг нарийвчлан тогтоож, зааварт нарийвчлан тусгаж өгөх шаардлага тулгарч байна.

Цагдаагийн хэсгийн байцаагчаас хариуцсан нутаг дэвсгэртээ нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн зөрчлийг шалган шийдвэрлэхэд олон ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэн гарсан үр дүндээ үндэслэн шийдвэрээ гаргадаг. Цагдаагийн хэсгийн байцаагч нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8, 5.1 дүгээр зүйлийн 5.1.1-5.1.5, 5.2 дугаар зүйлийн 1.1, 1.2, 5.3 дугаар зүйлийн 5.3.1, 5.3.2, 5.4 дүгээр зүйлийн 5.4.1, 5.5 дугаар зүйлийн 5.5.1, 6.1 дүгээр зүйлийн 6.1.1-6.1.3, 6.2 дугаар зүйлийн 6.2.1-6.2.7, 6.4 дүгээр зүйлийн 6.4.1-6.4.4, 6.5 дугаар зүйлийн 6.5.1, 6.6 дугаар зүйлийн 6.6.1-6.6.9, 6.7 дугаар зүйлийн 6.7.1, 6.10 дугаар зүйлийн 6.10.1-6.10.2, 6.11

⁵⁵ Төрийн мэдээлэл. 2007. №2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль:

⁵⁶ Төрийн мэдээлэл. 2017. №24. Зөрчлийн тухай хууль

дүгээр зүйлийн 6.11.1-6.11.3, 6.12 дугаар зүйлийн 6.12.1-6.12.3, 7.1 дүгээр зүйлийн 7.1.1-7.1.3, 7.3 дугаар зүйлийн 7.3.1-7.3.3, 7.4 дүгээр зүйлийн 7.4.1-7.1.5, 7.5 дугаар зүйлийн 7.5.1, 9.1 дүгээр зүйлийн 9.1.1-9.1.9⁵⁷ зэрэг нийт 20 зүйл, 66 хэсэгт заасан заалтуудыг эрх зүйн эх сурвалжаа болгон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаагаа явуулж байна.

Цагдаагийн байгууллагад Зөрчлийн тухай хуульд заасан нийт 52 зүйлийн 108 хэсэгт заагдсан зөрчил шалган шийдвэрлэхээр харьяалуулсанаас хэсгийн байцаагч нь 24 зүйлийн 61 хэсэгт⁵⁸ заасан зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.

Цагдаагийн хэсгийн байцаагч нь Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасныг үндэслэн хариуцсан нутаг дэвсгэрт согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэн хэв журмын зөрчил гаргасан иргэдийг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын саатуулах байранд хүлээлгэн өгч байна.

Хэсгийн байцаагч нь өөрийн хариуцсан нутаг дэвсгэр дээр байнга согтуурдаг, мансуурч олон нийтийн амгалан тайван байдлыг байнга алдагдуулдаг иргэдийг Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1-6.3, 7 дугаар зүйлийн 7.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.3, 9 дүгээр зүйлийн 9.7⁵⁹ зэрэг 5 зүйл 14 заалтад заасан дараахи ажил, арга хэмжээг үе шаттайгаар явуулж, албадан эмчилгээнд хамруулж байна. Үүнд, албадан эмчлүүлэх хүсэлт гаргах, дүгнэлт гаргуулах, лавлагаа авах, шүүхэд хүсэлт гаргах, шүүхийн шийдвэр гаргуулах, эмнэлгийн байгууллагад хүргэж өгөх зэрэг ажиллагаанууд орж байна.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд: Цагдаагийн хэсгийн байцаагчаас нийтийг хамарсан арга хэмжээний аюулгүй байдлыг хангах, хууль бус жагсаал цуглааныг албадан тараах, гал түймрийн аюул гарсан, гамшгийн аюул тохиолдсон, онц байдал тогтоосон үеийн үйл ажиллагаанд оролцох эрх зүйн үндэс нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 30 дугаар зүйлийн 30.1.7, 34 дүгээр зүйлийн 34.1.2⁶⁰, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 9.4,⁶¹ Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-13.3, 14 дүгээр зүйлийн 14.3⁶², Онц байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1.6, 16 дугаар зүйлийн 3.2⁶³ зэрэг нийт дөрвөн хуулийн найман зүйл, 10 заалтаар зохицуулагдаж байна.

⁵⁷ Төрийн мэдээлэл. 2017. №24. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль.

⁵⁸ Зөрчлийн тухай хуулийн 5.1-2, 5.3-1, 5.5-1, 5.7-1, 5.2.1-2, 5.4-3, 5.6-11, 5.8-1, 5.9-1, 5.13-1, 5.16-1, 5.19-1, 6.3-2, 6.5-5, 6.18-1, 6.20-1, 6.22-1, 8.8-1, 10.4-2, 10.26-2, 15.2-1, 16.9-2, 15.18.2-1 нийт 45 хэсэг болно.

⁵⁹ Төрийн мэдээлэл. 2018. №46. Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль

⁶⁰ Төрийн мэдээлэл. 2017. №7. Гамшгаас хамгаалах тухай хууль

⁶¹ Төрийн мэдээлэл. 2015. №28. Галын аюулгүй байдлын тухай хууль

⁶² Төрийн мэдээлэл. 1994. №9. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль.

⁶³ Төрийн мэдээлэл. 1996. №2. Онц байдлын тухай хууль.

Захиргааны хяналт тавих үүргийн хүрээнд: Цагдаагийн хэсгийн байцаагч нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.2, 15 дугаар зүйлийн 15.1⁶⁴, Галт зэвсгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.4, 24 дүгээр зүйлийн 24.1, 26 дугаар зүйлийн 26.5⁶⁵, Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1⁶⁶, Тамхины хяналтын тухай хуулийн 11 дугаар зүйлийн 11.1⁶⁷, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 162 дугаар зүйлийн 162.6, 180 дугаар зүйлийн 180.3, 189 дүгээр зүйлийн 189.6, 190 дүгээр зүйлийн 190.4⁶⁸ зэрэг нийт таван хуулийн 11 зүйл, 12 заалтыг эрх зүйн эх сурвалж болгон захиргааны хяналт тавих үүргээ хэрэгжүүлж байна.

- **Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор баталсан дүрэм, журам, бодлогын баримт;**

УИХ, ЗГ-аас баталсан дор дурдсан хөтөлбөрүүдийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд хамаарах зүйл заалтууд нь бодлогын шинжтэй зохицуулалт болохын зэрэгцээ хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн үндэс болон баримтлах зарчим болж байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр⁶⁹ УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4 /Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах чиглэлээр/-ийн 5.4.1, 5.4.5, 5.4.6, 5.4.8 дахь заалтууд нь хэсгийн байцаагчаас явуулах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тодорхойлж өгсөн эрх зүйн эх сурвалж болж байна. Дээрхи эрх зүйн зохицуулалтууд нь хэсгийн байцаагчийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй явагдах, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш, шударгаар үйлчлэх, цахим мэдээллийн системээр дамжуулан иргэдэд түргэн шуурхай, иргэдэд чирэгдэлгүй ажиллах, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах эрх зүйн эх сурвалж, нөгөө талаараа үйл ажиллагаандаа баримтлах зарчим гэж болж байна.

Энэхүү хөтөлбөрийн 5.3.5. “Гэр бүл, хүүхэдтэй холбоотой болон хүрээлэн байгаа орчин, газрын асуудалтай холбоотой хэрэг, маргааныг тухайн чиглэлээр мэргэшсэн шүүгч, прокурор, хууль сахиулах байгууллагын алба хаагч шийдвэрлэх механизмыг бүрдүүлнэ”⁷⁰ гэсэн заалт нь практикт төдийлөн хэрэгжиж чадахгүй байгаа зохицуулалт болж байна. Учир нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийг мэргэшсэн алба хаагч бус харин тухайн зөрчил, хэрэг, маргаан гарсан нутаг дэвсгэрийн хэсгийн байцаагч хариуцан шалгаж байгаа нь энэхүү хөтөлбөрийн зарим заалт хангалтгүй хэрэгжиж байна гэж үзэх үндэслэлийг бий болгож байна.

⁶⁴ Төрийн мэдээлэл. 2000. №6. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль.

⁶⁵ Төрийн мэдээлэл. 2015. №31 Галт зэвсгийн тухай хууль

⁶⁶ Төрийн мэдээлэл. 1998. №3. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль.

⁶⁷ Төрийн мэдээлэл. 2005. №27. Тамхины хяналтын тухай хууль.

⁶⁸ Төрийн мэдээлэл. 2017. №24. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

⁶⁹ <https://www.legalinfo.mn/annex/details/7409?lawid=12120>. УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол.

⁷⁰ <https://www.legalinfo.mn/annex/details/7409?lawid=12120>. УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол.

- “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”⁷¹

Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолоор батлагдсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр” нь цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон баримт бичиг болж байна. Энэхүү хөтөлбөрийн 5.1-д заасан сайн удирдлага зохион байгуулалт зорилтын 5.1.4, 5.1.5, 5.1.7 дахь заалтууд нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны чиглэл, удирдлага зохион байгуулалттай холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн эх сурвалж болж байна. Дээрхи гурван заалтуудын агуулгыг авч багцлан үзвэл цагдаагийн үйл ажиллагааг олон нийтийн дэмжлэгтэй нягт уялдуулан оролцоонд түшиглэн хэрэгжүүлэх, эрх мэдэл, хариуцлагыг оновчтой хуваарилах замаар нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагыг бие даан хөгжүүлэх, тогтоосон жишгийн дагуу ажил, үйлчилгээ үзүүлэх, гадаад орны цагдаагийн сайн туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх гэсэн агуулгыг хамаарч байна.

Дээрхи зохицуулалтуудаас 5.1.4-д заасан олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйл ажиллагаа зохих хэмжээнд явагдаж байгаа, харин 5.1.5-д заасан “Засгийн газраас тогтоосон жишгийн дагуу ажил, үйлчилгээ үзүүлэх” заалт хангалтгүй хэрэгжиж байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 153-р тогтоолоор батлагдсан “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив” өнөөдөр хэрэгжихгүй байгаа нь энэхүү хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг бууруулах нэг хүчин зүйл болж байна.

Хөтөлбөрийн 5.2. Мэргэшсэн үйл ажиллагаа зорилтын хүрээнд: 5.2.1. “цагдаагийн албаны хууль сахиулах үйл ажиллагааг стандарт, арга зүй, аргачлалын дагуу явуулах”, 5.2.4. “гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны стратеги, тактик арга зүйг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөгжүүлж, үйл ажиллагаанд ашиглах”, 5.2.5. “цагдаагийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээлэл цуглуулах, шалгах, үнэлэн шинжлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх үйл ажиллагааг технологийн хөгжилд тулгуурлан саадгүй, шуурхай зохион байгуулах” гэсэн заалтууд нь хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны арга зүйг тусгасан эрх зүйн зохицуулалиад хамаарч байна.

Хөтөлбөрийн 5.2.2-д цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааны стратеги, арга зүйн үзэл баримтлалыг тодорхойлж, үйл ажиллагаандаа ашиглахаар заасан боловч өнөөг хүртэл Цагдаагийн албаны тухай хууль болон холбогдох дүрэм, журам, зааварт энэ талаар тусгаагүй нь эрх зүйн зөрчилдөөнтэй байдлыг үүсгэж байна. Энэхүү хөгжлийн хөтөлбөрт цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд баримталбал зохих арга барилын үзэл баримтлалыг тусгаж өгсөн байх ёстой боловч тусгаагүй нь хөтөлбөрийн үр дүнг бууруулах нэг хүчин зүйл болсон байна.

- Хууль зүйн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр⁷²

⁷¹ <https://www.legalinfo.mn/annex/details/6264?lawid=9842>. ЗГ-ын 2014 оны 79 дүгээр тогтоол.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 29-ны өдрийн 63 дугаар тогтоолоор батлагдсан энэхүү хөтөлбөрийн 2.5.4.6. “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэрч, хохирогчийг хамгаалах, хүний эрхийг хангах бодлогын хэрэгжилтийг зохицуулах” гэсэн заалт нь хэсгийн байцаагчаас явуулах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд бодлогын шинжтэй үүрэг чиглэл өгөх, зарим шаардлагатай ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрх зүйн нэг эх сурвалж болж байна.

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр⁷³

Энэ хөтөлбөрийн 3.3.2. “иргэдийг мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, үр дагаврын талаарх мэдээллээр хангах, ухуулан таниулах ажлыг олон нийт, төрийн бус болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах” гэсэн заалт нь хэсгийн байцаагчаас явуулах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн нэг эх сурвалж юм.

Дээрхи УИХ, ЗГ-ын баталсан дөрвөн хөтөлбөрийн 14 зүйл заалтууд нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн хэсгийн байцаагчаас явуулах үйл ажиллагааны чиглэл, арга зүйг тодорхойлсон эрх зүйн зохицуулалтын нэг хэсэг болж байна.

Монгол Улсын сайд, агентлагийн даргын тушаалаар баталсан дүрэм, журам, заавар;

Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд. цагдаагийн хэсгийн байцаагчаас явуулах тодорхой чиглэсэн үйл ажиллагаануудыг ЦЕГ-ын даргын тушаалаар баталсан үйл ажиллагааны журмууд зохицуулж байна. Тухайлбал, ЦЕГ-ын даргын 2017 оны 12-р сарын 28-ны өдрийн А/262 тоот тушаалаар батлагдсан код 205, 223, 227, 228, 229, 240, А/263 тоот тушаалаар батлагдсан код 301, 307, 308, 12-р сарын 20-ны өдрийн А/249 тоот тушаалаар батлагдсан код 702, 703⁷⁴ зэрэг нийт 11 үйл ажиллагааны журмуудаар цагдаагийн хэсгийн байцаагчаас гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулагдаж байна.

Дээрхи журмуудын холбогдох зүйл заалтууд нь цагдаагийн хэсгий байцаагчаас гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалах, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүнийг баривчлах, төрийн байгууллагад хүргэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн тухай мэдээллийг төлбөртэй авах, эрэн сурвалжлах, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, гэрэл зураг, дуу авиа, дүрс бичлэг хийж, ашиглах, гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээд, алдагдсан эд зүйлийг эрж олоход ач холбогдол бүхий мэдээллийг илтгэх хуудсаар өгөх, хялбаршуулсан хэрэг бүртгэлт явуулах, зөрчлийн тоо бүртгэл хөтлөх, судалгаа, хяналтын тоо бүртгэл хөтлөхтэй холбоотой харилцааг зохицуулж байна.

⁷² <https://www.legalinfo.mn/law/details/8768>. Засгийн газрын 2012 оны 63 дугаар тогтоол.

⁷³ <https://www.legalinfo.mn/annex/details/7692?lawid=12557>. Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоол.

⁷⁴ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. УБ. 2018. 342-344, 397-404, 413-422, 422-446, 472-474, 491, 509-510, 821-838 дахь тал

Энэ нь цагдаагийн хэсгийн байцаагчаас гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үүссэн харилцааг дээр дурдагдсан үйл ажиллагааны журмууд бүрэн зохицуулж байна гэж үзлээ.

ЦЕГ-ын даргын 2003 оны 229 дүгээр тушаалаар батлагдсан “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ийн 6.А. Гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх 6.1-6.6, 6.В. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 6.20, 7.Хэсгийн байцаагчийн ажлын шуурхай байдлыг хангах 7.1.3⁷⁵ зэрэг нийт 8 хэсэгт заасан зүйл заалтууд нь цагдаагийн хэсгийн байцаагчаас гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагааны чиглэл, тодорхой үүсэх харилцааг зохицуулсан эрх зүйн эх сурвалж болж байна. Уг заавраар гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр зохицуулж буй харилцааны агуулгыг авч үзвэл, гэмт хэргийн тухай мэдээллийг хүлээн авч таслан зогсоох, учирч болох хор аюулыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх, хэргийн газрыг хамгаалалтад авах арга хэмжээ авах, холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх, гэмт хэргийг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэлтэй илтгэх хуудас бичих, сэжигтэн этгээд, эд зүйлийг эрэн сурвалжлах, баривчлах, хуулиар харьяалуулсан хэрэг, зөрчилд хэрэг бүртгэх ажиллагаа явуулахтай холбоотой харилцааг зохицуулжээ.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн “Албан тушаалын тодорхойлолт”-ын 1.1, 1.2, 1.6 зэрэг нийт 3 заалтууд гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн үйл ажиллагаанд хамаарч байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагаа нь 4 хуулийн 18 зүйлийн 55 хэсэг болон 11 журам, 1 зааврын 8 заалт, албан тушаалын тодорхойлолтонд заасан 2 зорилтын 4 заалтаар зохицуулагдаж байна.

Нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийн хүрээнд. Энэхүү чиг үүргийн хүрээнд цагдаагийн хэсгийн байцаагчаас явуулах тодорхой ажиллагаануудыг ЦЕГ-ын даргын баталсан үйл ажиллагааны журмаар зохицуулж байна. Тухайлбал: гэмт хэрэг, зөрчлийн талаархи гомдол мэдээлэл хүлээн авахтай холбоотой харилцааг ЦЕГ-ын даргын 2017 оны 12-р сарын 28-ны өдрийн А/262 тоот тушаалаар батлагдсан код 202, 203, 204⁷⁶, 232⁷⁷ зэрэг дөрвөн журмаар, хэв журмын зөрчлийг шалгах, хүүхдийн эрхийг хангах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхтэй холбоотой ажил, арга хэмжээ нь ЦЕГ-ын даргын 2017 оны 12-р сарын 28-ны өдрийн А/263 тоот тушаалаар батлагдсан код 316⁷⁸, 321⁷⁹, 326⁸⁰ 408⁸¹ зэрэг дөрөв, нийт найман журмуудаар зохицуулж байна.

Харин хэсгийн байцаагчаас эргүүлийн үүрэг гүйцэтгэх, албадан эмчилгээнд явуулах, албадан саатуулах, эрүүлжүүлэх, нийтийн болон хэв журмын урамшилтай

⁷⁵ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ. 2008. 427 дахь тал

⁷⁶ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. Эмхэтгэл. УБ. 2018. 323-342 дахь тал

⁷⁷ Мөн бүтээл. 486-488 дахь тал

⁷⁸ Мөн бүтээл. 527-530 дахь тал

⁷⁹ Мөн бүтээл. 538-540 дэх тал

⁸⁰ Мөн бүтээл. 546-553 дахь тал

⁸¹ Мөн бүтээл. 584-585 дахь тал

эргүүл, жижүүрийг мэргэжлийн удирдлагаар хангах, хамтран ажиллахтай холбоотой үйл ажиллагаа нь ЦЕГ-ын даргын 2019 оны 9-р сарын 04-ний А/196 тушаалаар батлагдсан “Цагдаагийн эргүүл, харуулын дүрэм”⁸², ЦЕГ-ын даргын 2017 оны 12-р сарын 28-ны өдрийн А/263 тоот тушаалаар батлагдсан код 401, 402⁸³, 404⁸⁴, 621, 622⁸⁵, 629⁸⁶ зэрэг зургаан журмаар зохицуулагдаж байна.

“Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ын 6.Б /Нийгмийн хэв журам хамгаалах чиглэлээр/-ийн 6.7, 6.8, 6.11, 6.18, 6.В /Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр/-ийн 6.21-6.23, 6.27, 6.Г /Цагдаа-олон нийтийн хамтын ажиллагааны чиглэлээр/-ийн 6.28-6.33⁸⁷ зэрэг нийт гурван зүйл, 13 хэсэгт заасан заалтаар нийтийн хэв журам хамгаалах үүрэг гүйцэтгэх цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагаа зохицуулагдаж байна.

Цагдаагийн хэсгийн байцаагчаас нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр “Албан тушаалын тодорхойлолт”-ын 1.3-1.6, 1.9-1.14, 2.1.а, б, в, г, д зэрэг 11 хэсэг, 5 заалтуудад заагдсан ажил үүргийг хэрэгжүүлж байна.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд: Цагдаагийн хэсгийн байцаагчаас олон нийтийн аюулгүй байдлыг хангах тодорхой ажил, арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хамгаалалт, хорио цээрийн дэглэм сахиулах үйл ажиллагаанд дангаар болон хамтран оролцох арга, хэлбэр, арга зүйг ЦЕГ-ын даргын 2017 оны 12-р сарын 28-ны өдрийн А/262 тоот тушаалаар батлагдсан код 211⁸⁸, А/265 тоот тушаалаар батлагдсан код 500⁸⁹, 502 - 506⁹⁰, 508⁹¹ зэрэг журмуудаар зохицуулж байна.

Цагдаагийн хэсгийн байцаагч нь “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ын 6.Б /Нийгмийн хэв журам хамгаалах чиглэлээр/-ийн 6.9, 6.10⁹²-д заасан үүрэг нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэгт хамаарч байна.

Харин “Албан тушаалын тодорхойлолт”-ын 1.8-д олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа явуулахтай холбоотой үүргийг багцлан оруулсан нь Цагдаагийн албаны тухай хуулийн 12-р зүйлд заасан олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэгтэй нийцэж байна.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд цагдаагийн хэсгийн байцаагч оролцохдоо Цагдаагийн албаны тухай хуулийн 59-р зүйл⁹³, Хэсгийн байцаагчийн ажлын зааврын 7.1.5⁹⁴-д заасан эрхийг эдэлнэ.

⁸² <https://police.gov.mn/a/4627>

⁸³ Мөн бүтээл. 571-578 дахь тал

⁸⁴ Мөн бүтээл. 580-581 дэх тал

⁸⁵ Мөн бүтээл. 785-787 дахь тал

⁸⁶ Мөн бүтээл. 800-806 дахь тал

⁸⁷ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ. 2008. 427-428 дахь тал

⁸⁸ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. Эмхэтгэл. УБ. 2018..373-375 дахь тал

⁸⁹ Мөн бүтээл. 595-629 дэх тал

⁹⁰ Мөн бүтээл. 641-650 дахь тал

⁹¹ Мөн бүтээл. 654-656 дахь тал

⁹² Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ. 2008. 427 дахь тал

⁹³ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль.

Захиргааны хяналт тавих чиг үүргийн хүрээнд: Захиргааны хяналтын үүргийн талаар “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ын 6.Б /Нийгмийн хэв журам хамгаалах чиглэлээр/-ийн 6.19, 6.24, 6.25, 6.26, “Албан тушаалын тодорхойлолт”-ын 1.5 дэх заалтуудаар хэсгийн байцаагч захиргааны хяналт тавих үйл ажиллагаа зохицуулагдаж байна.

Цагдаагийн хэсгийн байцаагчаас Цагдаагийн албаны тухай хуульд заасан захиргааны хяналтын үүрэг гүйцэтгэхтэй холбоотой тодорхой ажиллагаануудыг ЦЕГ-ын даргын 2017 оны 12-р сарын 28-ны өдрийн А/266 тоот тушаалаар батлагдсан код 600⁹⁵, 604, 605⁹⁶, 608⁹⁷, 615⁹⁸ зэрэг журмуудаар албадан нүүлгэх тухай Засаг даргын шийдвэрийг биелүүлэх, гэрээт харуул хамгаалалт, хувийн хамгаалалтын үйл ажиллагаа болон зарим хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, сэтгэцийн өвчтэй хүнийг эрж олоход туслахтай холбоотой харилцааг зохицуулж байна.

Захиргааны хяналтын үүргийн чиглэлээрхи дээрхи эрх зүйн зохицуулалтанд дүн шинжилгээ хийж үзвэл хэсгийн байцаагчийн үйл ажиллагаа нь 4 хуулийн 4 зүйлийн 7 хэсэг, үйл ажиллагааны 5 журам, хэсгийн байцаагчийн ажлын зааврын 5 заалт, албан тушаалын тодорхойлолтонд тусгасан 1 заалтаар зохицуулагдаж байна.

Хэсгийн байцаагчаас явуулах бусад харилцааны эрх зүйн зохицуулалтын хүрээнд: Цагдаагийн хэсгийн байцаагч нь ЦЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/262 тушаалаар батлагдсан “Хулгайлагдсан болон сураггүй алга болсон хүнийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах журам” /код 230/-ийн 230.3.3-аар Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний төв, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар болон эмнэлгийн байгууллагатай харилцах, “Хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах журам” /код 242/-аар олон нийтийн мэдээллийн байгууллагатай харилцах, “Олон нийтийн цагдааг ажиллуулах журам” /код 243/-аар олон нийтийн цагдаатай харилцах, А/265 тушаалаар батлагдсан “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах журам /код 507/-аар төрийн тусгай хамгаалалтын газартай харилцах, А/266 тушаалаар батлагдсан “Мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран ажиллах журам” /код 613/-аар мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн эх сурвалж тодорхойлогдож байна.

Цагдаагийн хэсгийн байцаагчаас нутаг дэвсгэрийн Засаг дарга, Иргэдийн болон Нийтийн хурал, хурлын Тэргүүлэгчидтэй хамтран ажиллахдаа “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ын 2 дугаар зүйл /Удирдлага, зохион байгуулалт/-ийн 2.2, 2.5, 10 дугаар зүйл /Хэсгийн байцаагч, сум, баг, хорооны Засаг даргын хамтын ажиллагаа/-ийн 10.1-10.8 зэрэг хоёр зүйлийн арван хэсэгт заасан заалтыг эрх зүйн эх сурвалж болгож байна.

⁹⁴ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ. 2008. 427 дахь тал

⁹⁵ Мөн бүтээл. 711-730 дахь тал

⁹⁶ Мөн бүтээл. 738-743 дахь тал

⁹⁷ Мөн бүтээл. 745-748 дахь тал

⁹⁸ Мөн бүтээл. 758-759 дэх тал

- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамжаар баталсан захиргааны хэм хэмжээ тогтоосон актын хүрээнд

Нийслэлийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх ажилтай холбоотой нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага, албан тушаалтнаас гаргасан тогтоол, захирамжуудыг цагдаагийн албаны тухай хуульд заасан чиг үүргийн хүрээнд ангилан сүүлийн таван жилээр нь авч үзвэл:

Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд: Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 сарын 03-ны өдрийн 126 дугаар тогтоолоор “Хөршийн хяналтыг хэрэгжүүлэх журам”⁹⁹, 2015 оны 10 сарын 16-ны 177 дугаар тогтоолоор “Сургуулийн эргүүлийн ажиллах журам”¹⁰⁰ -ыг тус тус баталсан байна. Тогтоолуудын агуулгыг багцлан авч үзвэл иргэн, оршин суугчид эвлэлдэн нэгдэж, амьдарч буй орчиндоо амар тайван, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, Ерөнхий боловсролын сургууль, түүний орчинд сурагчид гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөх, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажилд эцэг эхийг татан оролцуулах замаар эргүүл зохион байгуулахтай холбогдон үүссэн харилцааг зохицуулах зорилготой гаргасан журмууд байна.

Цагдаагийн хэсгийн байцаагч нь өөрийн хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хөршийн хяналтын бүлгүүд болон Ерөнхий боловсролын сургуулиудын орчинд ажиллаж буй сургуулийн эргүүлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах эрх зүйн үндсийг дээрхи журмууд олгож байна.

Нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийн хүрээнд: Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 04 сарын 14-ны өдрийн 57 дугаар “Олон нийтийн цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэх хорооны хэсгийн ахлагчийн ажиллах түр журам батлах тухай” тогтоолыг гаргасан байна. Энхүү тогтоолыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах болон шинэ төрлийн коронавирус халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан бөгөөд хэсгийн ахлагч нар нь олон нийтийн цагдаагийн ажилтны чиг үүргийг хэрэгжүүлж байгаагаас үүдэлтэйгээр хэсгийн байцаагч нь мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хамтарч ажиллахтай холбоотой харилцааг зохицуулж байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн нийтийн хэв журам сахиулахтай холбоотойгоор гаргасан 23 захирамж байх бөгөөд агуулгыг нь багцлан авч үзвэл газар чөлөөлөх, газрын зөрчил арилгах ажиллагааны явцад хэв журам сахиулахтай холбоотой долоо, хичээлийн шинэ жил эхлэхтэй холбоотой тав, шинэ жил, сар шинийн баярын үед хэв журам сахиулахтай холбоотой дөрөв, тэнэмэл, орон гэргүй иргэдийг нийгэмшүүлэхтэй холбоотой гурав, “эрсдэлгүй”, “шилдэг хороо” шалгаруулахтай холбоотой хоёр, “автомашингүй өдөр” арга хэмжээ

⁹⁹ Нийслэлийн нутаг дэвсгэрт захиргааны хэм хэмжээ тогтоосон актын эмхтгэл. УБ.2018. 261-266 дах тал.

¹⁰⁰ Мөн бүтээл. 267-269 дэх тал

зохион байгуулах, малтай иргэдийг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой тус бүр нэг захирамж гарсан байна.

Цаг хугацааны хувьд 2015 онд гурав, 2016 онд хоёр, 2017 онд нэг, 2018 онд ес, 2019 онд зургаа, 2020 онд хоёр захирамжыг тус тус гаргажээ.

Дээрхи захирамжуудад дүн шинжилгээ хийж үзвэл нийслэлийн бүх хэсгийн байцаагч нарын үйл ажиллагаатай шууд холбоотой арван дөрөв, хорооны онцлог байдлаас улбаатай ес байх бөгөөд бүгд нэг удаагийн шинжтэй захиргааны хэм хэмжээ агуулсан акт байна. */хавсрал №1/*

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахтай холбоотой 17 захиргааны хэм хэмжээ тогтоосон захирамж гаргажээ. Захирамжуудын агуулгыг нь багцлан авч үзвэл иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор аж ахуйн нэгжид үйл ажиллагааны хязгаарлалт тогтоосон дөрөв, хүн, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой долоо, үер, усны ослын аюулаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой гурав, гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, дадлагатай холбоотой хоёр, жагсаал, цуглаан албадан тараахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан байна.

Цаг хугацааны хувьд 2015 онд нэг, 2016, 2017 онд тус бүр гурав, 2018 онд нэг, 2019 онд дөрөв, 2020 онд таван захирамж тус тус гаргажээ.

Дээрхи захирамжуудад дүн шинжилгээ хийж үзвэл нийслэлийн бүх хэсгийн байцаагч нарын үйл ажиллагаатай шууд холбоотой ес, зарим хорооны онцлог байдлаас улбаатай найман захирамж байх бөгөөд бүгд нэг удаагийн шинжтэй захиргааны хэм хэмжээ агуулсан акт байна. */хавсрал №1/*

Өөрөөр хэлбэл мал бүхий иргэд амьдардаг төвөөс алсдагдсан болон нийслэлийн төвийн бүсэд орших хороод хариуцсан хэсгийн байцаагч нарт хамааралтай захирамжууд цөөнгүй байна.

Захиргааны хяналтын үүргийн хүрээнд: Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 06 сарын 06-ны өдрийн 25/20 дугаар тогтоолоор “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам”¹⁰¹ батлагдсан байна. Энэхүү журмын зорилго нь түргэн үйлчилгээний цэгүүдийн бизнес эрхлэгч иргэдийн эрх ашгийг хангах, аюулгүй байдал, стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнээр иргэдэд үйлчлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэгдсэн бөгөөд хэсгийн байцаагч нар нь өөрсдийн хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа түргэн үйлчилгээний цэгүүдэд хяналт тавих эрх зүйн харилцааны үндэс болж байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг хязгаарлах, түүний хэрэгжилтэнд захиргааны хяналт тогтоохтой холбоотой 11 захирамж гаргасан байна. Захирамжийн агуулгыг багцлан авч үзвэл, худалдаа, үзвэр, үйлчилгээний аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоохтой холбоотой гурав, түүхий нүүрсний хэрэглээ

¹⁰¹ <https://www.zasag.mn/news/view/22842>

болон сайжруулсан түлшний борлуулалттай холбоотой хоёр, хараа хяналтгүй хүүхдийн талаар авах арга хэмжээний талаар гурав, хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэхтэй холбоотой нэг захирамж гаргасан байна.

Цаг хугацааны хувьд авч үзвэл 2015 онд гурав, 2017, 2018 онд тус бүр нэг, 2019 онд гурав, 2020 онд хоёр захирамж тус тус гаргажээ. Үйлчилж буй хүчин чадлын хувьд нийслэлийн нийт хэсгийн байцаагч нарт хамааралтай найм, хорооны онцлог байдлаас үүдэлтэйгээр зарим хэсгийн байцаагч нарт хамааралтай гурван захирамж байна. Өөрөөр хэлбэл түүхий нүүрс болон хууль бус мод бэлтгэлтэй холбоотой захирамжууд нь зөвхөн алслагдсан болон гэр хороололтой хороодын хэсгийн байцаагч нарт хамаарч байна. Захирамжуудын үйлчилж буй эрх зүйн чадамж талаас нь авч үзвэл тав нь нэг удаагийн шинжтэй, зургаа нь тодорхой хугацаанд үйлчлэхээр байна.

Хэсгийн байцаагчаас хуульд тогтоомжид заасан үүргээ хэрэгжүүлэх, тодорхой ажиллагаа явуулах хүрээнд: Цагдаагийн хэсгийн байцаагч нь Цагдаагийн албаны тухай хууль болон “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”, “Албан тушаалын тодорхойлолт”-оор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ Цагдаагийн албаны тухай хуулийн 23-33, 35-37, 46, 47, 49, 52, 54, 55, 58¹⁰² -р зүйлд заасан тодорхой ажиллагаануудыг явуулдаг.

Хуулийн дээрхи зүйлд заасан заалтуудаар цагдаагийн хэсгийн байцаагчаас иргэн, хуулийн этгээдэд шаардлага тавих, тайлбар авах, баримт бичиг шалгах, иргэнийг түр саатуулах, орон байр, бусад газарт нэвтрэн орох, үзлэг хийх, эд зүйл, баримт бичиг түр хураан авах, согтуурсан, мансуурсан байдлыг шалгах, тээврийн хэрэгслийг зогсоож шалгах, хөдөлгөөнийг хязгаарлах, түр саатуулах, зорчих хөдөлгөөнийг хязгаарлах, зам чөлөөлөх, хөдөлгөөний чиглэлийг түр өөрчлөх, хаах, биечилсэн судалгаа хийх, гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, албадлагын арга хэмжээ хэрэглэх, биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулж байна.

Дээр дурдсан тодорхой ажиллагаануудыг ЦЕГ-ын даргын 2017 оны 12-р сарын 28-ны өдрийн А/262 тоот тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны код 213-225, 240, 245 журамд заасан арга, хэлбэрээр явуулахаар журамласан байна.

Дүгнэлт. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хүрээнд хэсгийн байцаагчаас явуулах тодорхой ажиллагаа нь Цагдаагийн албаны тухай хуулийн 18 зүйл, үйл ажиллагааны 15 журам, ажлын зааврын 5 заалтаар зохицуулагдаж байна.

Цагдаагийн албаны тухай хуульд заасан 4 чиг үүргийн хүрээнд хэсгийн байцаагчаас явуулж буй үйл ажиллааны дээрхи бүх эрх зүйн зохицуулалтанд дүн шинжилгээ хийж үзвэл 21 хуулийн 87 зүйл, 137 хэсэг, 38 журам, хэсгийн ажлын зааврын 30 заалт, албаны тушаалын тодорхойлолтын 2 зорилтын 20 заалтаар зохицуулагдаж байна.

¹⁰² Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

Нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийн хүрээнд цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааг тодорхойлсон дээрхи бүх эрх зүйн зохицуулалтанд дүн шинжилгээ хийж үзвэл хэсгийн байцаагчийн үйл ажиллагаа нь 10 хуулийн 55 зүйлийн 135 хэсэг, 3 дүрэм, 14 журам, хэсгийн байцаагчийн ажлын зааврын 14 заалт, албаны тушаалын тодорхойлолтын 14 заалтаар зохицуулагдаж байна.

Гэвч хэсгийн байцаагчаас явуулах нийтийн хэв журам хамгаалахтай холбоотой үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт нь хуучин Цагдаагийн байгууллагын тухай хууль”-д үндэслэн боловсруулсан “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ын зарим зүйл заалтуудтай нийцэхгүй, ажлын байрны чиг үүргийг тодорхойлсон “Албан тушаалын тодорхойлолт”-тод байхгүй чиг үүргийг тусгасан зэргийг үндэслэн эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэхэд учир дутагдалтай гэж үзэж байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараахь саналыг дэвшүүлж байна.

1. Цагдаагийн албаны тухай хуульд нийцүүлэн “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ыг шинэчлэн боловсруулах;
2. Хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээг нарийвчлан тодорхойлж, зааварт тусгаж өгөх;
3. “Албан тушаалын тодорхойлолт”-д тусгасан гүйцэтгэх үүргийн давхардлыг арилгаж, шинэчлэн боловсруулах;

ПОЛНОМОЧИЯ ОМБУДСМЕНА КЫРГЫЗСКОЙ РЕСПУБЛИКИ В ОБЛАСТИ СОВЕРШЕНСТВОВАНИЯ НАЦИОНАЛЬНОГО ЗАКОНОДАТЕЛЬСТВА

Саидов Фархад Зирофович

Адъюнкт кафедры государственно-правовых дисциплин Академии

Управления МВД России г. Москва, капитан милиции

E-mail: aa_navsegda@mail.ru

Аннотация: в статье рассматривается деятельность Омбудсмена Кыргызской Республики по обеспечению прав и свобод человека и гражданина. Его полномочия в области совершенствования национального законодательства согласно требованиям Конституции Кыргызской Республики, общепризнанным принципам и международным договорам, которые были ратифицированы парламентом страны. Наделить Омбудсмена Кыргызской Республики правом законодательной инициативы в области прав и свобод человека и гражданина.

Ключевые слова: омбудсмен, права и свободы человека и гражданина, законодательная инициатива, парламент.

Кыргызская Республика в настоящее время признает, что права человека являются высшей ценностью государства и стремится построить правовое государство в основе которого заложена концепция права человека.

Важной задачей государства является приведение национального законодательства в соответствие с Конституцией Кыргызской Республики, законами и международными договорами по правам человека, которые были ратифицированы Жогорку Кенешем Кыргызской Республики (парламентом). Конституция Кыргызской Республики признает, что человеческое достоинство неприкосновенно, права и свободы человека принадлежат ему от рождения, защищаются законом от посягательств со стороны кого бы то ни было. Жизнь человека и его здоровье, личная неприкосновенность и безопасность, право собственности являются ценностями государства¹⁰³.

Обеспечение соблюдения прав и свобод человека и гражданина - это главная обязанность публичной власти. Нарушение прав человека и основных свобод могут быть не только личной трагедией, но и могут создать условия для социальных, политических беспорядков и порождают насилие, конфликты в обществе. Кыргызская Республика являясь членом мирового сообщества, принимает на себя обязательства по защите прав человека в соответствии с международными стандартами, закрепленными в международных договорах.

¹⁰³ Конституция Кыргызской Республики от 27 июня 2010 года

Фундаментом создания института омбудсмена в Кыргызской Республики послужил Указ Президента Кыргызской Республики «Об учреждении Комиссии по правам человека при Президенте Кыргызской Республики» в 1997 году. В 1998 году Комиссия начала свою деятельность. До 2002 года Комиссия по правам человека выполняла задачи и функции специализированного органа по защите прав и свобод человека и гражданина, согласно «Парижским принципам».

Следующим этапом по введению должности Омбудсмена Кыргызской Республики стала национальная программа «Права человека», утвержденной Указом Президента Кыргызской Республики от 2 января 2002 года, где, было предусмотрено принятие Закона Кыргызской Республики «Об Омбудсмене (Акыйкатчы)» для усиления эффективности системы несудебной защиты прав и свобод человека и гражданина. Исходя из вышеуказанного 21 ноября 2002 года прошли первые выборы Омбудсмена Кыргызской Республики в результате которого был избран первый Омбудсмен Кыргызской Республики, который обеспечивает права и свободы человека и гражданина.

Согласно Закону Кыргызской Республики «Об Омбудсмене (Акыйкатчы) Кыргызской Республики» парламентский контроль за соблюдением конституционных прав и свобод человека и гражданина на территории Кыргызской Республики и в пределах ее юрисдикции на постоянной основе осуществляет Омбудсмен (Акыйкатчы) Кыргызской Республики¹⁰⁴. В Законе Кыргызской Республики «Об Омбудсмене (Акыйкатчы) Кыргызской Республики» с 2007 года Омбудсмен имеет право оказывать содействие совершенствованию законодательства:

- 1) получать планы законопроектной деятельности Жогорку Кенеша и Правительства и внесенные в Жогорку Кенеш проекты законов;
- 2) участвовать в рабочих группах по подготовке проектов законов;
- 3) давать заключения на направленные соответствующими органами законопроекты;
- 4) обращаться с предложениями к субъектам права законодательной инициативы об изменении или дополнении действующего законодательства Кыргызской Республики;
- 5) вносить предложения о заключении, денонсации или приостановлении действия международных договоров.

В настоящее время правом оказывать содействие в совершенствовании законодательства пользуется очень активно в 2018 году он направил 15 предложений субъектам законодательной инициативы и 20 заключений на законопроекты. Но при этом необходимо отметить, что Омбудсмену приходится проделать большой путь, чтобы быть услышанным, затем убедить субъекта законодательной инициативы в правильности своих доводов. Таким образом, процесс участия Омбудсмена в

¹⁰⁴ Закон Кыргызской Республики «Об Омбудсмене (Акыйкатчы) Кыргызской Республики» от 31 июля 2002 года №136 статья 1

совершенствовании национального законодательства в настоящее время носит сложный характер. В действительности, деятельность Омбудсмена Кыргызской Республики в совершенствовании законодательства в области прав человека без посредников может приносить свою плодотворность, потому что именно ведомства омбудсмена осуществляет регулярный анализ жалоб граждан, а также мониторинг соблюдения прав человека должностными лицами органов публичной власти, органов местного самоуправления, предприятий, организаций и учреждений независимо от форм собственности.

Осуществляет взаимодействие с должностными лицами органов публичной власти, органов местного самоуправления, предприятий, организаций и учреждений независимо от форм собственности принимая совместные оперативные решения на проблемы общества. Наделив Омбудсмена Кыргызской Республики правом законодательной инициативы в области прав человека и гражданина будет приносить свои плоды. Предоставив Омбудсмену право законодательной инициативы в области прав человека и гражданина в настоящее время является требованием современного мира. Согласно Конституции Кыргызской Республики статье 79 право законодательной инициативы принадлежит:

- 1) 10 тысячам избирателей (народная инициатива);
- 2) депутату Жогорку Кенеша Кыргызской Республики (парламент);
- 3) Правительству Кыргызской Республики.

Исходя из вышеуказанного, чтобы наделить Омбудсмена Кыргызской Республики правом законодательной инициативы в области прав человека и гражданина необходимо изменить и дополнить Основной закон страны и Закон Кыргызской Республики «Об Омбудсмене (Акыйкатчы) Кыргызской Республики», предусмотрев норму, что Омбудсмен имеет право законодательной инициативы в области прав и свобод человека и гражданина.

Правом законодательной инициативы сегодня обладают Уполномоченные по правам человека в субъектах Российской Федерации. Например, Уполномоченный по правам человека Санкт-Петербурга, Республики Татарстан, Ингушетии, Алтайского и Пермского края, Иркутской, Архангельской, Самарской и Московской областей, которые успешно реализовывают свои права по законодательной инициативе в области прав человека и гражданина.

Оказывать содействие совершенствованию законодательства в области прав человека и гражданина Омбудсмен имеет право обратиться в Конституционную палату Верховного суда Кыргызской Республики. Согласно функциональным обязанностям Омбудсмена, он имеет право оценивать содержание нормативно-правовых актов на предмет их соответствия положениям Конституции Кыргызской Республики, общепризнанным принципам и международным договорам по правам человека, ратифицированным парламентом. Омбудсмен Кыргызской Республики если примет решение, что нормы закона противоречат Конституции, общепризнанным принципам и международным договорам в области прав человека, он имеет право обратиться в Конституционную палату Верховного суда Кыргызской

Республики с ходатайством о признании таких положений неконституционными и прекращении их действия¹⁰⁵.

Тем не менее несмотря на сложности перед ведомством омбудсмена, он показывает свою эффективность в 2018 году письменных и устных обращений составило 11 260. Большинство обращений граждан это жалобы на правоохранительные и судебные органы. Исходя из вышеуказанного в настоящее время государством проводятся судебная реформа по обеспечению прав человека на справедливое и достойное правосудие на основе верховенства права в соответствии с международными нормами. В результате реформы были приняты Административно-процессуальный кодекс¹⁰⁶, Гражданско-процессуальный кодекс¹⁰⁷, Уголовно-процессуальный кодекс¹⁰⁸, Уголовный кодекс¹⁰⁹, Уголовно-исполнительный кодекс¹¹⁰, Кодекс о проступках¹¹¹, Кодекс о нарушениях¹¹², Закон Кыргызской Республики «О статусе судебных исполнителей и об исполнительном производстве»¹¹³, Закон Кыргызской Республики «Об основах амнистии и порядке ее применения»¹¹⁴, которые вступили в силу с 1 января 2019 года. Принятие новых законодательств в настоящее время не разрешает проблем которые существуют в практической деятельности, теперь для ведомства омбудсмена необходимо проводить тщательный анализ каждой нормы закона, чтобы приводить в порядок с нормами Конституции, общепризнанным принципам и международным стандартам в области прав человека и гражданина, а если наделить Омбудсмена Кыргызской Республики правом законодательной инициативы увеличит эффективность деятельности ведомства омбудсмена.

Таким образом, Омбудсмен Кыргызской Республики - это конституционный орган, независимый от органов государственной власти, органов местного самоуправления, во время выполнения своих функциональных обязанностей по обеспечению прав и свобод человека и гражданина. Согласно Конституции Кыргызской Республики и Закону Кыргызской Республики «Об Омбудсмене (Акыйкатчы)» осуществляет парламентский контроль за соблюдением прав и свобод

¹⁰⁵ Закон Кыргызской Республики «Об Омбудсмене (Акыйкатчы) Кыргызской Республики» от 31 июля 2002 года №136 статья 8, п.3

¹⁰⁶ Кодекс Кыргызской Республики от 25 января 2017 года №13 «Административно-процессуальный кодекс Кыргызской Республики»

¹⁰⁷ Кодекс Кыргызской Республики от 25 января 2017 года №14 «Гражданский процессуальный кодекс Кыргызской Республики»

¹⁰⁸ Кодекс Кыргызской Республики от 2 февраля 2017 года №20 «Уголовно-процессуальный кодекс Кыргызской Республики»

¹⁰⁹ Кодекс Кыргызской Республики от 2 февраля 2017 года №19 «Уголовный кодекс Кыргызской Республики»

¹¹⁰ Кодекс Кыргызской Республики от 31 января 2017 года №17 «Уголовно-исполнительный кодекс Кыргызской Республики»

¹¹¹ Кодекс Кыргызской Республики от 1 февраля 2017 года №18 «О проступках»

¹¹² Кодекс Кыргызской Республики от 13 апреля 2017 года №58 «О нарушениях»

¹¹³ Закон Кыргызской Республики «О статусе судебных исполнителей и об исполнительном производстве» от 28 января 2017 года №15

¹¹⁴ Закон Кыргызской Республики «Об основах амнистии и порядке ее применения» от 20 января 2017 года №7

человека и гражданина, является основным элементом правозащитной системы государства, оказывает содействие по обеспечению национального законодательства в области прав человека, в соответствии международным стандартам, тем самым оказывая парламенту, правительству, судебным органам поддержку в применении норм, касаемо прав и свобод человека и гражданина. На современном этапе развития на ведомство омбудсмена возложена большая ответственность по обеспечению прав и свобод человека и гражданина. Действительно, надо признать, что наделив Омбудсмена полномочием законодательной инициативы в области прав человека и гражданина повлечет обязанность Жогорку Кенеша Кыргызской Республики (парламента) непосредственно рассматривать предложения Омбудсмена по изменению и дополнению положений законов, которые действительно противоречат Конституции, другим нормативным актам и международным договорам в области прав человека.

СПИСОК ЛИТЕРАТУРЫ:

1. Конституция Кыргызской Республики от 27 июня 2010 года
2. Кодекс Кыргызской Республики от 25 января 2017 года №13 «Административно-процессуальный кодекс Кыргызской Республики»
3. Кодекс Кыргызской Республики от 25 января 2017 года №14 «Гражданский процессуальный кодекс Кыргызской Республики»
4. Кодекс Кыргызской Республики от 2 февраля 2017 года №20 «Уголовно-процессуальный кодекс Кыргызской Республики»
5. Кодекс Кыргызской Республики от 2 февраля 2017 года №19 «Уголовный кодекс Кыргызской Республики»
6. Кодекс Кыргызской Республики от 31 января 2017 года №17 «Уголовно-исполнительный кодекс Кыргызской Республики»
7. Кодекс Кыргызской Республики от 1 февраля 2017 года №18 «О проступках»
8. Кодекс Кыргызской Республики от 13 апреля 2017 года №58 «О нарушениях»
9. Закон Кыргызской Республики «О статусе судебных исполнителей и об исполнительном производстве» от 28 января 2017 года №15
10. Закон Кыргызской Республики «Об основах амнистии и порядке ее применения» от 20 января 2017 года №7
11. Закон Кыргызской Республики «Об Омбудсмене (Акыйкатчы) Кыргызской Республики» от 31 июля 2002 года №136

ГЭР БҮЛ БА ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн
багш, цагдаагийн дэслэгч Д.Цэрэнлхам.*

Товч агуулга: Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар, мөн гэмт хэрэг үйлдэхэд эцэг, эхийн үүрэг оролцоо, гэр бүлийн орчин хэрхэн нөлөөлдөг талаар судалж, уг өгүүлэлээр Монгол Улсад хэрэгжүүлж болох урьдчилан сэргийлэх сайн туршлагын талаар санал дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг: Гэр бүл, хүүхэд, гэмт хэрэг, зөрчил, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга хэмжээ.

Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенцид “18 насанд хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ¹¹⁵” гэж тодорхойлсон байдаг. Сүүлийн үед хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төр засаг, цагдаа, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудаас тодорхой ажлуудыг санаачлан хийж байгаа боловч хүүхэд гэмт хэрэг үйлдэж гэмт хэрэгтэн болсоор байна.

Монгол Улс 1,3 сая орчим хүүхэдтэй бөгөөд улсын хэмжээнд насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг авч үзэхэд 2015-2019 он буюу сүүлийн 5 жилийн хугацаанд 5845 хүүхэд 13 төрлийн гэмт хэрэг үйлдсэн байна¹¹⁶.

Тодруулбал 14-16 хүртлэх насны этгээд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэмт хэрэг болох “Хүнийг санаатай алах”, “Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах, “Хүчиндэх”, “Бусдын эд хөрөнгийг хулгайлах”, “Бусдын эд хөрөнгийг булаах”, “Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх”, “Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах, гэмтээх”, “Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар танхайрах” гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ¹¹⁷ гэж заасан байдаг.

Гэхдээ эндээс үзвэл зөвхөн гэмт хэрэг ч бус мөн гэмт үйлдэлд тооцогдохгүй бусад олон үйлдлүүд хамаарах юм. Жишээлбэл орон гэрээсээ зугатах, сургуулиа хаях, хууль ёсны асран хамгаалагч болон эцэг эхийн хууль, ёс суртахууны хүрээнд тавьсан шаардлагыг үл биелүүлэх зэрэг үйлдлүүд орно.

Улс, орнуудад насны хязгаарыг янз бүрээр хуульчилсан ч олонхийн наснаас доогуур байгаа учраас “Насанд хүрээгүй хүн” гэсэн үг хэллэгийг хэрэглэж, хуулийн дагуу хүүхэд буюу нийгмийн цөөнх гэсэн бүлэгт хамааруулна.

¹¹⁵ Хүүхдийн эрхийн тухай конвенци., 1989 он.

¹¹⁶ Police.gov.mn. ЦЕГ-ын Гэмт хэрэг, зөрчлийн 2015-2019 оны статистик, тоон мэдээ

¹¹⁷ Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар., 2013 он, 78 дахь тал

Гэхдээ “хүүхэд” эсвэл “насанд хүрээгүй хүн” гэх хууль, эрх зүйн тогтолцоонд хэрэглэж буй үг хэллэгийг хүний биологийн болон сэтгэл зүйтэй холбоотой өсөлт хөгжилт, биеийн ерөнхий бойжилт бүрэн явагдах, эсвэл нийгэмд эзлэх байр суурь нь төлөвшсөн зэрэгтэй шууд холбон авч үзэж болохгүй юм.

Насанд хүрээгүй хүмүүс согтууруулах ундаа уух, тамхи татах зуршил, өсвөр насны хүүхдүүдийн бүлэглэл, тэдний үйлдсэн хүчирхийлэл, Өсвөр насны хүүхдийн үйлдсэн бусад олон төрлийн гэмт хэрэг, зөрчил одоог хүртэл нийгмийн анхаарлыг татсан хэвээр байна.

Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, холбогдсон насанд хүрээгүй хүмүүсийн хувийн байдлыг судлахад дийлэнх нь урьд өмнө нь өөрөө гэмт хэргийн улмаас хохирч байсан нь ихээхэн сонирхол татаж байгаа бөгөөд нийтлэг байдлаар нь үзвэл эцэг, эхийн хайр халамж дутах, ядуурал, ажилгүйдэл, тэнүүчлэл, бусдын сөрөг нөлөө, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нь энэ төрлийн гэмт хэргийн үндсэн шалтгаан нөхцөл болдог.

Энэ дундаас эцэг, эхийн үүрэг оролцоо, гэр бүлийн орчин энэ төрлийн гэмт хэргийн гол шалтгаан болж байна гэж тодорхойлж болно.

Сэтгэл сэвтүүлсэн нэг үйл явдлын улмаас ганцхан өдрийн дотор гэр бүл салаад явчихгүй нь ойлгомжтой. Ихэнх тохиолдолд хувь хүний зүй зохистой бус зан чанар, чадвар, чадамж, санхүүгийн хямрал, ханийн итгэл эвдсэн үйлдэл болон бусад шалтгааны улмаас буюу дараалж хуримтлагдсан хэд, хэдэн үйл явдал, нөхцөл байдлын үр дүнд гэр бүл салах шийдвэр гардаг. Тэдгээр учрал, зөрчилдөөн өрнөх бүрт эцэг, эхийн хооронд маргаан, хэрүүл, дайсагнал давтан гарч, гэр орондоо байгаа хүүхдүүд бүхнийг харж, сонсч, сэтгэл нь сэвтэж байдаг. Ийм орчинд байгаа хүүхдийн зан авир, төлөвшилд өөрчлөлт орж улмаар гэмт хэрэгтэн болох нөхцөл бүрдэж байдаг.

Цаашлаад ийм зөрчилдөөний улмаас нийгмийн харилцааны сөрөг бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг нийгмээс хөндийрөх уур амьсгал гэр бүлийн гишүүдийн дунд бий болохыг үгүйсгэхгүй.

Хүүхэд хүмүүжлийн эхний хичээлээ гэр бүлээсээ авдаг. Гэр бүлийнх нь амьдрал, хүмүүсийн байр байдал, хоорондын харилцаа нь хүүхдэд ямар нэгэн эргэлзээгүйгээр шууд дагах мөрдлөг, амьдралын суурь зарчим болдог.¹¹⁸

Гэмт хэрэг, зөрчил үйлдэж байгаа хүүхдийн шалтгааныг гэр бүлийн орчноос тодруулбал:

Эцэг, эх, асран хамгаалагчаас шалтгаалах:	Хүүхдээс шалтгаалах:
 Гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж буй	 Хүүхдийн ухамсар, хүмүүжлийн доголдолтой байдал;

¹¹⁸ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны гарын авлага., 2017 он.

✚ хүчирхийлэл; ✚ Эцэг, эхчүүдийн хэрүүл маргаан, таагүй харилцаа; ✚ Гэр бүл салалт; ✚ Эцэг, эхийн хараа хяналт сул, халамж анхаарал төдийлөн тавьдаггүй байдал; ✚ Гэр бүлийн орчин дахь эцэг, эхийн архидалт; ✚ Хүүхдийн нас, бие бялдар, хөгжлийн онцлогийг мэддэггүй, анзаардаггүй; ✚ Хүүхэдтэй зөв харьцах, тэднийг хүмүүжүүлэх арга барил дутмаг.	✚ Амар хялбар аргаар мөнгө олох сэтгэлгээтэй болсон; ✚ Амьдралын үнэ цэнийг мөнгөтэй холбон үзэх үзэл бодол бий болсон ✚ Сэтгэл зүйн хатуужил, эр зоригийн хүмүүжил, бие даасан байдал төлөвшөөгүй; ✚ Хүүхдийн өөрийнх нь эмзэг байдал, ганцаардал; ✚ Найз нөхдийн сөрөг нөлөө, бусдыгаа уруу татах; ✚ Хүүхдийн сониуч гэнэн зан, дэмүү сэлгүүцэх, атаман байхыг хүсдэг байдал; ✚ Насанд хүрэгчдийн гар, хөл болох, гэмт хэрэг үйлдэхэд нь оролцох, хамтрах.
---	--

Орчин үеийн нийгэмд нийт гэрлэгсдийн тэн хагас нь салж, гэр бүлийн бүтэц хойд эцэг, эх эсвэл ганц бие эцэг, эх болж өөрчлөгдөж байгаа нь харамсалтай. Холилдсон гэр бүлүүд хоёр хүүхэд эсвэл олон эцэг эхчүүдийн нэгдлээс бүрдэх боллоо. Түүнчлэн маш олон хүүхэд хэт залуу эсвэл гэрлээгүй эцэг, эхчүүдийн гэрт мэндэлж байгааг та бид өдөр тутамдаа мэдээ, мэдээллээс харж байна.

Мөн аз жаргалгүй уур амьсгал давамгайлсан гэр оронд эцэг, эх ба хүүхдийн хооронд хүндрэлтэй нөхцөл байдал үүснэ. Энэ нь ёс суртахууны доголдлын ерөнхий онол ба нийгмийн барилдлагын онолтой холбогдож байгаа юм. Өөрөөр хэлбэл хүүхдийг хэт их албадсанаар хүүхэд хэдэр, дайсагнасан, цадиггүй араншинтай болж эцэстээ гэмт хэргийн замд ороход хүргэдэг.¹¹⁹

Хүүхэд гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд хүргэдэг гэр бүл доторх харилцааны гол онцлог бол гэр бүлийн гишүүдийн харилцан бие биедээ үзүүлж буй нөлөөлөл гэж зарим судлаачид үздэг. Магадгүй эцэг эхчүүдийн зүгээс хүүхдээ хянахдаа-маргаантай, мөн үр нөлөө муу сахилга батын аргуудыг хэрэглэж болно. Заримдаа, магадгүй ихэнх тохиолдолд эцэг буюу эх, эсвэл эцэг эх хоёулаа хүүхдийн хүсэл сонирхол, шаардлагыг биелүүлдэг, энэ нь хүүхэд эсэргүүцэх, сөрөх байдлаар хандах зуршил, дадалтай болоход сургаж байгаагаас өөрцгүй, цаашлаад хязгаарлах, хориглох хэв шинжтэй аливаа шаардлага тавихад хүүхэд эсэргүүцлээ хадгалах сэтгэхүйг зан араншиндаа шингээдэг.

Ингээд хүүхэд зан байдлын олдмол араншингаа гэр орноос гадуур орчинд гаргаж, муу үр дагавартай үйлдэл хийж болно. Түүний зан байдлыг хүлээж авахгүй үе тэнгийн хүүхдүүдэд дургүй болж эхлэх агаад улмаар өөрийн зан байдалд тохирсон нэгнийг сонгодог. Харин сонгогдсон тэр хүүхэд өөртэй нь адилхан сахилга батгүй, дайсагнасан, сөрсөн хандлагатай нэгэн байдаг.

¹¹⁹ Орегоны Нийгмийн Судлалын Төв буюу OSLC-ийн эрдэмтдийн судалгаанаас.

Эцэг, эх хүүхдийнхээ харилцааны хүндрэлд буруугаар оролцох нь хүүхэд, залуусын зан чанарт эсэргүүцэж, сөргөлдсөн шинжийг суулгаж; юу хийхийг нь зааж, зааварласан тохиолдолд шууд дайсагнах, тэмцэлдэх, үл ойшоох хандлагатай болдог. Эцэг, эхийн үр нөлөөгүй, зүй зохисгүй харилцаа бол нөхцөл байдлыг улам дордуулах төдийгүй хүүхдийг эсэргүүцсэн, зөрчилдсөн хариу үйлдэл хийхэд сургадаг. Үүнээс гадна үр нөлөө муутай эцэг эхийн үйлдэл ямар ч хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөмхий болоход хүргэнэ. Цаг хугацааны талаас авч үзвэл хүүхдийг бага балчир байсан ч, өсвөр насанд байлаа ч, мөн бага залуу насанд ч эцэг эхийн буруу хандлага муу нөлөө үзүүлдэг юм. Эцэг эхийн зааварчилгаа, шаардлагыг биелүүлдэг, хууль ёс, дүрэм журмаа дагадаг хүүхдүүд хүртэл эцэг эхийн хараа, хяналт сулрах, хэт ширүүн харьцах, бусад хэв маягаар үр нөлөө муутай хандах явдалд эмгэгшиж, зан чанарын өөрчлөлттэй болох магадлал их. Гэр бүлийн хүчин зүйлсийг урт хугацааны туршид судлахад эцэг эхийн хараа, хяналт ба сахилга батын үр нөлөө муутай харьцаа зэрэг хувьсамтгай олон нөлөөллийн улмаас өсвөр насны хүүхдийн ёс суртахуун доголдож, цаашдаа гэмт хэрэг, зөрчил үйлдэх замд ордог болох нь тогтоогдсоор байгаа юм.

Харин Америкийн нэгдсэн улсад Гэр бүлийн доторх харилцаа, холбоо ба гэмт хэрэг, зөрчлийн талаарх анхны судалгааг судлаас Глук 1950 онд хийжээ. Тэрээр гэр бүлийн 5 харилцаа байдаг¹²⁰ гэж үзсэн бөгөөд Үүнд:

1. Эцгийн сахилга бат;
2. Эхийн хараа хяналт;
3. Хүүхэддээ санаа тавьдаг эцгийн сэтгэл;
4. Хүүхэддээ санаа тавьдаг эхийн сэтгэл;
5. Гэр бүлийн эв нэгдэл.

Сахилга бат нь тууштай, зохистой шинжтэй, тийм ч хатуу, чанга биш (бие махбодийн шийтгэл шаардлагагүй, гэхдээ хараалын үг хэллэг, зүй бус харьцаагаар илэрнэ); харин хараа хяналт бол “хэр хэмжээндээ тохирсон” ба “голч, шударга”, ойр дотно, халуун дулаан, сэтгэл татмаар байх шинжтэй бол гэр бүлийн эв нэгдэл нь гэмт хэрэг, зөрчилтэй шалтгаант холбоо бараг байхгүй болгох нөхцөл байдалд тооцогддог.

Судлаач Найе-ийн судалгаанд гэр бүлийн биет бүтэц гэхээс илүүтэй гэр бүл доторх харилцаа, холбоо нь гэмт хэрэг, зөрчлийг тайлбарлахад илүү чухал хэмээн дүгнэжээ. Эцэг, эх ба хүүхдүүд болон гэр бүлийн гишүүдийн дундах сэтгэл санааны таатай холбоо, баяр баясгалантай харилцаа, ойр дотно байдал нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд шууд нөлөөлнө. Харин эцэг эсвэл эх үгүй гэр бүлийн тухайд ийм холбогдол бараг үгүй гэхэд болно.

Орон гэрт үүссэн асуудал цаашлаад олон нийтийн хүрээнд ороход сургуульд сурах, ангийн орчинд байхад хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэнэ. Учир нь багш нар болон үе тэнгийн бусад сурагчид зүй зохистой харьцаа, харилцаа, хариуцлагатай байдлыг зайлшгүй шаардах нь гарцаагүй. Одоо хүүхэд багш нар

¹²⁰ Судлаач Саймонс 2004., 51.

болон үе тэнгийн хүүхдүүдтэй муу харилцаатай болсноор сургууль дээрээ нилээд хэцүү асуудалтай нүүр тулж, сурлагад нь ч муугаар нөлөөлнө. Ингээд асуудал овоорох тусам хүүхдийн хувьд нөхцөл байдал дордож, сургууль, гэр орондоо тогтох боломжгүй болсноор гэмт хэрэг, зөрчлийн замд өөрийн эрхгүй орно.

Насанд хүрээгүй хүн гэмт хэрэгт холбогдоод байгаагийн шалтгаан нөхцлийг тодруулах судалгаа¹²¹-г гэмт хэрэгт холбогдсон 40 хүүхэд, тэдний ар гэр, асран хамгаалагчид болох 40 хүн, нийт 80 хүмүүст хийсэн судалгааны дүнгээс харахад гэмт хэрэгт холбогдоод байгаа хүүхдүүдийн дийлэнх хувь нь 16-18 насны хүүхдүүд байсан.

Судалгаанд хүүхдүүдийн асран хамгаалагчдаас аав нарыг хамруулахыг зорьсон боловч судалгаанд оролцсон хүмүүсийн 72.5% нь эмэгтэйчүүд байсан бөгөөд үүний 57.5% нь төрсөн ээжүүд нь байна. Үүнээс харахад өрх толгойлсон эхчүүдийн хүүхдүүд гэмт хэрэгт холбогдож байгаа нь илүү их харагдаж байна. Мөн хүүхдүүдийн зүгээс эцэг, эхийнхээ ойр дотно харилцааны байдлыг үнэлсэн үнэлгээнээс харахад эцэг, эхчүүд хүүхдээ хэт хамгаалдаг буюу дээд түвшин нь 85% байна. Тухайлбал: “Танай хүүхэд энэ хэргийг санаачилсан уу?” гэсэн асуултад 77% нь үгүй гэж хариулт өгсөн.

Харин асрамж, халамжийн түвшин нь дунд буюу дундаас доош байгаа нь эцэг, эхийн халамж муу байгаагаас хүүхдүүд гэмт хэрэгт холбогдох нэг шалтгаан гэж үзэж болохоор юм.

Бие махбодийн шийтгэл ба өсвөр насны хүүхдийн гэмт хэрэг, зөрчил: Эцэг, эх ба хүүхдүүд болон гэр бүлийн гишүүдийн дундах сэтгэл санааны таатай байдал, баяр баясгалантай харилцаа, ойр дотно байдал нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд шууд нөлөөлдөг.

Манай ард түмний хувьд “Таван салаа боов”-ны амтыг үзээгүй, мэдрээгүй хүн тун ховор байх. Ямартаа л шинэ Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр хүүхэддээ гар хүрэх нь битгий хэл чангахан дуугарч болохгүй боллоо хэмээн шүүмжлэх хүн олон байсан. Энэ байдал зөвхөн манай улсад төдийгүй өөр улс, оронд байдаг нэгэн хүмүүжлийн арга юм.

Тухайлбал: Хүүхдээ таван настай байхад нь бөгсөн дээр нь алгадах зэргээр биед нь гар хүрсэн гэж АНУ-ын эцэг, эхчүүдийн 90 хувь нь хариулсан байдаг¹²².

“Бие махбодид нь мэдрүүлж шийтгэх нь зөрүүд, сөрөг чиг хандлагатай хүүхдийг хянах үр нөлөөтэй арга мөн үү?” гэх асуултыг та хаа сайгүй сонссон бизээ. Энэ сэдвээр ярилцах үед хүүхэд хүч хэрэглэсэн гэмт хэрэг үйлдэх эсвэл гэмт хэрэгт холбогдох үйлдэл хийх том эрсдэл зэргийг хамруулан авч үзвэл сөрөг үр дагавартай гэхээс илүү бие махбодийн шийтгэлийн эерэг нөлөөг сайшаасан яриаг (саваагаа гамнавал хүүхдээ баллана) голдуу сонсоно. Гэвч түр ба байнгын алин боловч

¹²¹ Судлаач Д.Эрдэнэбаатар., 2018 он.

¹²² Juvenile delinquency 2016 он., 94 дэхь тал.

анхаарал халамж тавьдаг асран хамгаалагч, эцэг, эхчүүдийн зүгээс эерэг болон сөрөг талыг шууд хэлж, сонгон хэрэглэж чадахгүй буй заа.

Зарим нэг нь уурлаж, догширсон байдлаар хүүхдийн биед гар хүрэхгүй байхыг зөвлөдөг. Бие махбодид нь өвдөлт амсуулж шийтгэх, эсвэл бөгсөн дээр нь алгадах нь ерөнхийдөө хүчирхийллийн замаар сэтгэлийн дарамт эсвэл уйтгар, гунигаа давж гарахыг хүүхдэд зааж, сургадаг бөгөөд ач холбогдол байдаг эсэх талаар судлаачид нилээд маргалддаг.

Австри, Кипр, Дани, Финланд, Герман, Итали, Норвеги, ялангуяа Швед зэрэг улсуудад бие махбодид нь өвдөлт мэдрүүлэх замаар сахилга баттай байхад сургах хууль бус аргыг хэрэглэсээр иржээ¹²³. Хэдийгээр хүүхдийн зүй бус зан чанарыг богино хугацаанд хянахад тустай ч хүүхдийн биед гар хүрч шийтгэх нь хүч хэрэглэх хандлагатай болон гэмт хэрэг, зөрчилд өртөмтгий зан араншинтай болгох зэрэг урт хугацааны туршид сөрөг үр дагаварт хүргэдэг гэсэн нотолгоонуудыг Мюррей Страус болон түүний хамтрагчид гаргаж тавьсан юм.

Хүүхдийг гар эсвэл өгзөг дээр алгадах зэргээр зөөлөн гар хүрэх нь гараа атгаж, нудраглан цохих, эсвэл эд зүйлээр цохихоос илүү эерэг үр нөлөөтэй төдийгүй ирээдүйд гэмт хэрэг үйлдэх, хүч хэрэглэх дадал, зуршилтай болохоос урьдчилан сэргийлээд зогсохгүй зохисгүй зан авираа татахад тустай. Хүүхдийг хөнгөн зодож шийтгэхийн хажуугаар халуун дулаан харьцаа, эцэг эхийн хайр энэрэлийг мэдрүүлэх замаар хүмүүжүүлэх нь хүүхдийг сайн хүн болгох нэг хүчин зүйлс юм.

Гэр бүл дотор хүүхдэд зааж, сургах, хянаж залруулах үйл ажиллагааг бие махбодид нь хөнгөн өвдөлт мэдрүүлж сахилгажуулах үйл явцтай хослуулах нь ач холбогдолтой мэт санагдана. Ерөнхийдөө шийтгэлийн цаана хайр, халамжаа илэрхийлэх зорилго орших нь юу л бол, тиймээс зодож, бэртээхгүй, биеийг нь өвтгөхөөс зайлсхийж хүмүүжүүлэх нь зүйтэй болов уу. Сахилга баттай байлгахыг хүсэх хүлээлт, хандлагын цаана эцэг, эхийн жинхэнэ хайр, халамж, энэрэнгүй сэтгэл орших аваас хүүхдийн зан чанар, араншин эерэг хандлагатай байх, сэтгэцийн ямар нэгэн хүндрэл үүсэхгүй нөхцлийг бүрдүүлэхэд тустай бизээ.

Өсвөр үеийн хүүхдүүд амьдралдаа учирсан зовлон, зүдгүүрийг давж туулах арга замыг мэдэхгүйн улмаас зүгээр л эсэргүүцэх, дайсагнах, түрэмгий байдлаар хариу барих зэргээр аашилдаг, цаашлаад ийм хандлага зан авирт нь төлөвшиж, гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд эмзэглэх сэтгэлгээ нь алдагдана. Мөн хүчирхийлэл, доромжлол үргэлжилсэн, байнгын шинжтэй гэр бүлд өссөн хүүхдүүд гэр бүлийн ядуурал, сэтгэцийн өвчинд нэрвэгдэх магадлал өндөр юм. Түүнчлэн гэмт хэрэг, зөрчилд холбогдсон байдал нь тэдний хүчирхийлэлд өртсөн зовлонг хаацайлах шалтаг болдог. Гэтэл тэднийг хохирогч гэхээс илүү өөрийн үйл хөдлөл, зан чанарын өмнөөс хариуцлага хүлээх ёстой хүн гэж хардаг нь нөгөө талаас өрөөсгөл ойлголт байхаар харагддаг...

¹²³ Страус 1994, 179-81; Саймонс 2004, 60 дахь тал.

Гэр бүл ба гэмт хэрэг, зөрчлийн шалтгаант холбооны өөр нэгэн хэсэг бол айл хөрш, зэргэлдээх орчны тухай ухагдахуун юм. Гэр бүл хаана оршиж, амьдарч байгаагаас шалтгаалан өсвөр насны хүүхэд гэмт хэрэг, зөрчилд холбогдох эрсдэл бий болно.

Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх эрсдэл ихтэй нутаг, дэвсгэрт амьдарч буй хүүхэд, залуус эрсдэл багатай орчинд амьдардаг хүүхдүүдийг бодвол гэмт хэрэг, зөрчилд холбогдох магадлал өндөр байдаг. Үүний шалтгаан нь мөн л өрхийн амьжиргааны түвшин, цаашлаад орчны нөлөөлөл, гэр бүлийн гишүүдийн боловсрол, соёл, хандлага гээд олон хүчин зүйлүүдээр илэрч байдаг.

Айл хөрш, зэргэлдээх орчны талаар судалгаа хийх бас нэгэн сэдэв хөндөгдөж буйг уншигч та бодох буй заа.

Дүгнэлт: Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, холбогдсон насанд хүрээгүй хүмүүсийн хувийн байдлыг аваад үзэхэд дийлэнх нь урьд өмнө нь өөрөө гэмт хэргийн улмаас хохирч байсан нь ихээхэн сонирхол татаж байгаа төдийгүй насанд хүрээгүй хүмүүсийн дунд зохиох урьдчилан сэргийлэх ажлыг нийгмийн бусад салбарын үйл ажиллагаатай хослуулах хэрэгцээ байгааг харуулж байна.

Мөн түүнчлэн өсвөр насны хүүхдийн гэмт хэрэг, зөрчлийг хам сэдвийн хүрээнд судлах, энэ төрлийн гэмт хэрэг өсөлт бууралтанд гэр бүл чухал үүрэг гүйцэтгэнэ. Эцэг эсвэл эх нь салж, сарнисан гэр бүл нь гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлдөг талаар зарим нэг нотолгоо байгаа ч эдгээрийн хоорондох шалтгаант холбоо тийм ч хүчтэй, тогтмол шинжтэй биш ажээ.

Гэр бүл ба өсвөр насны хүүхдийн гэмт хэрэг, зөрчлийг холбон авч үзэх чухал зүйл бол эцэг эх ба хүүхдүүдийн харилцаа, мөн гэр бүлийн бүх гишүүдийн халуун дулаан уур амьсгал юм. Хайр халамж дутуу, туйлбаргүй, хэт хатуу зан авиртай, үлгэр дууриалгүй, хараа хяналт тавьдаггүй эцэг, эхчүүдийг ерөнхийд нь өсвөр насны гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлөх хүчин зүйлс гэж үзнэ. Шууд бус утгаар тайлбарлавал гэр бүл бол гэмт хэрэг багасах эсвэл ихсэхэд нөлөөлнө гэсэн үг.

Эцэг эх нь салж, сарнисан гэр бүл ба өсвөр насны хүүхдийн гэмт хэрэг, зөрчилд хийсэн дэлгэрэнгүй судалгаанаас үзвэл ийм төрлийн гэр бүлд байгаа хүүхэд гэмт хэрэг, зөрчил үйлдэх магадлал өндөр ч нөгөө талаас бусад олон хүчин зүйлсийн улмаас гэмт хэрэгт холбогдсон гэх тоо баримт бага байдаг гэж харагдаж байна.

Санал:

1. Гэр бүлийн боловсролыг бүх нийтээр олгох;
2. Сум, дүүрэгт гэр бүлийг дэмжих, хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх;
3. Хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагчийг хамтад нь сургалтад хамруулж, эцэг, эх, хүүхдийн хамтын харилцааны талаар сургадаг байх.
4. Гэмт хэрэг үйлддэг, үйлдэж болзошгүй хүүхэдтэй ажиллахдаа мэргэшсэн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийг ажиллуулах.

ВЬЕТНАМЫН УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ АЛДАГДУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Д.Эрдэнбаатар*

Г.Лхагвамаа**

Дин Ван Ту***

Товч агуулга. Сүүлийн жилүүдэд Вьетнам Улсын хуульзүйн салбарын судлаач эрдэмтэд олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, нийтийн хэв журмын эсрэг гэмт хэрэг түүнд хүлээлгэх хариуцлагын үр нөлөөг сайжруулах асуудлын хүрээнд шийдвэрлэх арга замыг эрэлхийлж, эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход анхаарал хандуулах болсон.

Иймд судлаачийн зүгээс нийтийн хэв журам алдагдуулах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж, хэлбэр, түүнд хүлээлгэх хариуцлагыг өнөөгийн Вьетнамын Улсын Эрүүгийн хуульд хэрхэн хуульчлагдсан байдалд үндэслэн хөндсөн болно.

Түлхүүр үгс. Вьетнам улс, эрүүгийн хууль, нийтийн журам алдагдуулах гэмт хэрэг, гэмт хэргийн бүрэлдэхүүн, хүлээлгэх хариуцлага.

Оршил. Вьетнам улс 96,208,984 хүн амтай¹²⁴, 331,211.6 км² газар нутагтай¹²⁵ Зүүн өмнөд Азийн нутагт оршдог. Хүн амын нягтаршил өндөр байгаагаас сүүлийн жилүүдэд нийгэм, эдийн засгийн байдал хурдацтай хөгжсөнөөр, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолд халдаж, нийтийн хэв журмыг алдагдуулах гэмт хэргийн гаралт хурдацтай өсөн нэмэгдэх болсон. /Хүснэгт №1-ээс харна уу/

Хүснэгт № 1. Олон нийтийн газар үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт /2015- 2020 оны эхний хагас жилийн байдлаар/

Олон нийтийн газар үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт							
Он	Нийт	Гэмт хэрэгтний тоо	Гэмт хэргийн төрөл				
			НХЖАБ ¹²⁶	Эдийн засаг	Хар тамхи	Хүрээлэн байгаа орчин	Бусад
2015	33298	46278	30167	462	919	124	1626
2016	35478	48169	32137	478	1038	101	1724

ОХУ-ын эрдэмтэн Д.А.Николайн судалснаар 5-7 насны хүүхдийн анхаарал ойролцоогоор 15 минут, 7-10 насны хүүхдийнх 20, 10-12 насны хүүхдийнх 25, 12-оос дээш насныхны анхаарал ойролцоогоор 30 минут төвлөрдөг¹⁴⁴ гэдэг нь тогтоогджээ.

Тиймээс мөрдөгч насанд хүрээгүй хүнийг нэг удаа мэдүүлэг авахдаа хоёр цагаас илүүгүй хугацаагаар авах нь тухай хуулийн заалтыг дээд хязгаар нь гэж

¹⁴² Г.Ганбаатар. Гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй холбогдсон гэмт хэргийг мөрдөх арга зүй. УБ, 2019 он, 45 тал

¹⁴³ Ц.Бүжинлхам. Монгол Улсын ЭБШЗ/тусгай анги/. УБ., 2007., 194 дэх тал.

¹⁴⁴ Д.А.Николай. Особенности показаний малолетних и несовершеннолетних свидетелей и тактика допроса. Автореф. дисс... канд. юрид. наук. М., 1993. с.7

ойлгож насны онцлогтой холбогдох анхаарал төвлөрлийн хугацааг тооцоолох нь үр дүнтэй.

Судлаачдын үзэж байгаагаар мэдүүлгийг анхаарал төвлөрөх хугацаа дуусмагц завсарлах, мэдүүлгийн төгсгөлд хүүхдийн сэтгэл зүйг хэвийн байдалд оруулах зорилгоор энгийн яриа өрнүүлэх нь хүүхдийн эрүүл мэндэд тустай байдаг аж.

Анхаарах асуудлын нэг нь гэмт хэрэг үйлдэгдсэн гэж сэрдэгдэж байгаа өсвөр насны этгээдээс гэрчийн мэдүүлэг авах явдал юм. ЭХХШТХ-ийн 25.2 дугаар зүйлд арван найман насанд хүрээгүй хүнээс гэрчийн мэдүүлэг авахдаа түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл төрөл, садангийн хүн, сурган хүмүүжүүлэгчийг оролцуулах бөгөөд тэдэнд эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухай тэмдэглэлд тусгах талаар тодорхой заасан байна.

Харин өсвөр насны сэжигтэн, яллагдагчийн хувьд ЭХХШТХ-ийн 5.3 дугаар зүйлд зааснаар өмгөөлөгч заавал оролцуулах тухай хуульчилсан.

Иймд гэмт хэрэг үйлдэгдсэн гэж сэрдэгдэж байгаа өсвөр насны этгээдээс мэдүүлэг авахдаа түүний хууль ёсны төлөөлөгч, сурган хүмүүжүүлэгчээс гадна өмгөөлөгчийг заавал оролцуулах нь тухайн ажиллагааг нотлох баримтаар тооцуулан, үнэлж, хэргийг эцэслэн шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм.

Дүгнэлт. Практик амьдралд өсвөр насны сэжигтэн, яллагдагч холбогдсон гэмт хэрэгт мөрдөгч болгон ажиллагаа явуулдаггүй, жилдээ 1 хэрэгт, эмэгтэй мөрдөгчид 2-3 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулдгийг фокус ярилцлагын үр дүн харуулсан.

Дээрх судалгаа нь тухайн чиглэлээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах арга барил дутмаг, өсвөр насны этгээдийн сэтгэл хөдлөл, оюун ухаан, сэтгэхүйн шинж, насны онцлог байдалд тохирсон ажиллагааг үр дүнтэй явуулж чададгийг харуулж байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэлд дараахь саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Өсвөр насны сэжигтэн, яллагдагчийн холбогдсон гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах ажиллагааны урт болон богино хэмжээний сургалтуудыг тогтмол зохион байгуулан, алба хаагчдыг мэргэшүүлэх, тухайн чиглэлээр дагнасан мөрдөгчдийг тусгайлан бэлтгэх,

2. Хүүхэд, гэр бүл хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн болон төрийн бус байгууллагатай Мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг тасаг, хэлтсүүдийн хамтын ажиллагааг сайжруулах ажил арга хэмжээг зохион байгуулах, /Тодорхой төрлийн мөрдөн шалгах ажиллагаанд уг байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх/

3. Нийслэлийн Цагдаагийн Удирдах газрын Мөрдөн шалгах газарт өсвөр насны сэжигтэн, яллагдагчийн холбогдсон гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг тусгайлсан нэгж байгуулах¹⁴⁵ хэрэгцээ шаардлагыг судлан, эрх бүхий албан тушаалтанд танилцуулах,

4. Өсвөр насны этгээдийн үйлдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн судалгаанд тулгуурлан урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг тогтмол зохион байгуулан, үр дүнг тооцдог байх.

¹⁴⁵ Зөвхөн 2019 онд Улаанбаатар хотод 787 өсвөр насны этгээд гэмт хэрэг үйлдсэн

Ашигласан материал

1. Монгол Улсын Эрүүгийн хууль. 2015 он
2. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он
3. УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимийн 2009 оны N61 дугаартай зөвлөмж
4. Минимальные стандартные правила Организации Объединенных Наций, касающиеся отправления правосудия в отношении несовершеннолетних (Пекинские правила) ООН 1985 года Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын наад захын жишиг дүрэм /Бээжингийн дүрэм/ 1985 он
5. Г.Ганбаатар. Гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй холбогдсон гэмт хэргийг мөрдөх арга зүй. УБ, 2019 он
6. Ц.Бүжинлхам. Монгол Улсын ЭБШЗЗ /тусгай анги/. УБ., 2007 он
7. Д.А.Николай. Особенности показаний малолетних и несовершеннолетних свидетелей и тактика допроса. Автореф. М., 1993
8. К.И. Леонова, В.И. Диденко “Особенности производства предварительного расследования в отношении несовершеннолетних”. Проблемы правоохранительной деятельности, М., 2018
9. Улсын хэмжээнд 2015 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ
10. Улсын хэмжээнд 2016 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ
11. Улсын хэмжээнд 2017 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ
12. Улсын хэмжээнд 2018 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ
13. Улсын хэмжээнд 2019 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖЛЫГ МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИД ХУУЛЬЧИЛЖ ИРСЭН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

Д.Бямбахүү

*Дотоод хэргийн их сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн багш,
докторонт, цагдаагийн хошууч*

Товчлол. Эрэн сурвалжлах ажил нь цагдаагийн байгууллагын гол үүргийн нэг бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Энэхүү өгүүллээр эрэн сурвалжлах ажлыг Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид хэрхэн хуульчилж ирсэн түүхэн уламжлалын талаар товч өгүүлсэн болно.

Түлхүүр. Эрэн сурвалжлах ажил, хууль, цагдаагийн байгууллага

Үндсэн хэсэг. Засгийн газрын 1923 оны 6 дугаар сарын 26-ны 18 дугаар хурлаар баталсан "Цагдан цээрлүүлснийг зөрчсөнийг яллах хууль"-ийг цагдан сэргийлэх байгууллагын анхны дүрэм гэж үздэг. Учир нь уг хууль батлагдсан үед цэргийн яамнаас хуулийг биелүүлэх зорилгоор 1923 оны 06 дугаар сарын 16-ны өдөр тунхаглан зарлах бичиг гаргаж, түүндээ Нийслэл хүрээний газар архи ууж мөрийцөж наадах, хэрүүл шуугиан өдүүлэх шөнийн цагт чимээ гаргах, гудамж зээлд хог буртаг орхих, гал усны аюул болох, хулгайлах, булаах, харштай орон сав барих зэрэг бүхий л гаж самуунтэй тэмцэж бага, сага хэргийг цагдан сэргийлэх хороо шийдвэрлэж байх эрх олгосон нь хууль гэж үзэж болно¹⁴⁶.

1924 оны 11 сард Улсын анхдугаар хурал хуралдаж Монгол улсыг “Бүгд найрамдах Монгол Ард Улс” гэж тунхаглан анхдугаар Үндсэн хуулийг батлан гаргасантай холбоотойгоор 1926 онд “Шүүх цаазын бичиг”, түүний агуулгын хэрэгжилтийг хангах илэрхийлэл болох “Шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх хууль” баталж мөрдүүлсэн байна .

Уг хуулийн арван дөрөвдүгээр зүйл. Аливаа эрүүгийн хэрэг тохиолдсоны дараа цагдан сэргийлэх газраас харьяат ойр ангийн байцаагч түшмэлд мэдэгдэхээс гадна, түүний биенийг хүрэлцэн эрхээс нь урьдаар байцааж байвал зохино. Хорин хоёрдугаар зүйл. Аливаа хүнийг барих ба нэгжих хэрэгт байцаагч түшмэдээс бусад албаны хүмүүс харьяат албаны газарын эрх баригчид үсэг зурсан үнэмлэх тэмдэгт бичиг олгож явуулбал зохихийн дээр мөн бичгийг уул хүнд эрх биш урьдаар үзүүлбэл зохино. Тайлбарлах нь. Аливаа хүмүүсийг барихад түүний гэрийн ба захиргааны газар мэдэгдвэл зохино¹⁴⁷ гэж заажээ.

Аливаа эрүүгийн хэргийг хэрхэн байцаах ба шийтгэх тухай хууль: /1935 он/

¹⁴⁶ Б. Баярсайхан, Ч.Дашням, Д.Батжаргал, Ж.Энхнасан, Г.Оюунболд, Д.Сумъяацэрэн. Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал.2012он. 26-27 дахь тал

¹⁴⁷ БНМАУ-ын Засгийн газрын албаны сэтгүүл. 1926. №13. 34-65 дахь тал

Аливаа хэргийг хэрхэн байцаах ба шийтгэх тухай хуулийн 6 бүлгийн 43 дугаар зүйлд “Аливаа эрүүгийн хэргийг дээрхи газруудаас өөр ямар нэгэн газруудаас байцаан шийтгэж үл болох боловч зарим нэг онц чухал хэрэгт засгийн газраас тусгайлан эрх олгогдсон эрх бүхий газраас энэхүү хуулийн журмыг баримтлан таслан шийтгэж болно” гэж заасан байна. Засгийн газрын 1934 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 3 дугаар хурлаар “Ардын цагдан сэргийлэх газрын шинэ дүрэм”-ийг баталжээ. Дүрэмд цагдан сэргийлэх байгууллагын эрх үүргийг тусгаарлаж өгсөн бөгөөд оргодол болон ор сураггүй бологсдыг эрэн сурвалжлах, олдож ирсэн эд юмс, баримт бичгийг хадгалах, шүүхийн таслан шийтгэсэн тогтоолыг хэрэгжүүлэхэд туслах зэрэг шинэ үүргүүд тусгагдсан байна.

Аливаа эрүүгийн хэргийг хэрхэн байцаах ба шийтгэх тухай хуулийн тавин долдугаар зүйл. Шүүн таслах газруудаас байцаан шийтгэх хурлыг явуулахдаа заавал хэрэгтэн хүний биеийг завлаж суулцуулан гүйцэтгэвэл зохих Үүнд: Хэрэв хэрэгтний бие оргож зайлсан буюу. Эсхүл үнэхээр хүнд өвчтэй зэрэг учраас таслан шийтгэх хуралд ирж чадахгүй байвал тухай баримтыг гаргуулан авахаас тухайн учрыг хуралд сонсгон түүний биегүйгээр уг хэргийг шууд таслаж уул баримтыг хэрэгт хавсаргаж байцаал болгож байвал зохино хэмээн тусгажээ.

Бүгд найрамдах монгол ард улсын бага хурлын тэргүүлэгчдийн зарлиг /1949.07.30/

1940 оны Үндсэн хуулийн агуулга зарчимд нийцүүлэн 1949 оны 7 дугаар сарын 30-ны өдөр Улсын бага хурлын тэргүүлэгчдийн 4 дүгээр зарлигаар БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг баталсан. Энэ хууль нь 5 хэсэг, 26 бүлэг, 440 зүйлтэй тэр үеийн ЗСБНХУ-н Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хуулбарласан гэж зарим судлаачид үздэг. Энэ үеэс эрэн сурвалжилж баривчлахад тогтоолыг прокуророор батлуулж хүний эрхийг хангах тал дээр нилээд дэвшил гарчээ.

Уг хуулийн Долоо. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийн 99 дүгээр зүйлд заасан ёсоор Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ард иргэдийн биед халдаж үл болох явдлыг хангана. Шүүхийн тогтоолгүй буюу прокурорын зөвшөөрөлгүйгээр хэн хүнийг баривчилж үл болно¹⁴⁸.

Нэг зуун жаран долоо. Яллагдагч этгээд онц шалтгаангүйгээр хүрэлцэн эс ирвэл бол түүнийг албадан авчирна. Яллагдагч этгээд мөрдлөгөөс нуугдан зайлсхийвэл мөрдөн байцаагч урьдаар дуудахгүйгээр шууд албадан авчруулах эрхтэй болно. Яллагдагчийг албадан авчируулахдаа мөрдөн байцаагчаас шалтгааныг зааж гаргасан бөгөөд прокуророор батлуулсан тогтоолоор гүйцэтгэвэл зохино.

Нэг зуун жаран ес. Яллагдагчийн суугаа газар мэдэхгүй буюу оргон зайлсан бол мөрдөн байцаагчаас түүнийг эрж олох тухай тогтоол гаргана гэж хуульчилжээ.

Бүгд найрамдах монгол ард улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль /1963.12.24/

¹⁴⁸ Б. Баярсайхан, Ч.Дашням, Д.Батжаргал, Ж.Энхнасан, Г.Оюунболд, Д.Сумьяацэрэн. Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал.2012он. 127-151 дахь тал

Монгол орон социализм байгуулах зорилтын хүрээнд 1960-иад оны эхэн үеэс эрх зүйн бүхий л баримт бичиг Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН)-ын шийдвэр нөлөөлөх болсон байна. Иймээс эрх зүйн зохицуулалтыг өөрчлөн шинэчилж эхэлсэн байна. Тухайлбал, Эрүүгийн хууль (1961 он), Иргэний хууль (1963 он), Эрүүгийн байцаан шийтгэх хууль (1963 он), Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль (1966 он), Иргэний байцаан шийтгэх хууль (1967 он), Хөдөлмөрийн хууль (1973 он), Гэр бүлийн хууль (1973 он), Прокурорын хяналтын хууль (1976 он), Шүүхийн байгууламжийн хууль (1978он)-ийг тус тус батлан мөрдүүлэхийн зэрэгцээ тэдгээрт олон тооны нэмэлт, өөрчлөлт оруулж, мөн холбогдох бусад эрх зүйн актыг тэдгээрт нийцүүлэн батлан гаргаж байсан байна.

БНМАУ-ын АИХ-ын чуулганаар 1963 оны 12 дугаар сарын 24-ний өдөр ЭБШХ-ийг шинэчлэн баталсан нь 7 хэсэг, 36 бүлэг, 410 зүйлтэй бөгөөд 1964 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн байна¹⁴⁹. Энэ хуульд шүүх, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэх байгууллага өөр өөрсдийн эрх хэмжээний үүрэг хэмээн хуульчилж өгсөн давуу талтай.

Бүгд найрамдах монгол ард улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль 4-р зүйл. Эрүүгийн хэргийг үүсгэн явуулах ба гэмт хэргийг илрүүлэх үүрэгт. Гэмт хэргийн шинж тэмдэг илэрсэн тухайд шүүх, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэх байгууллага өөр өөрсдийн эрх хэмжээний дотор эрүүгийн хэрэг үүсгэж, гэмт хэрэг гарсан байдал ба гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох, түүнд ял шийтгэл оногдуулах талаар хуульд заасан бүх арга хэмжээ авах үүрэгтэй.

Уг хуулийн 122-р зүйлийн Хэрэг бүртгэх байгууллагын үүрэгт. Хэрэг бүртгэх байгууллага нь гэмт хэрэг ба түүнийг үйлдсэн этгээдийг олж илрүүлэхийн тулд зайлшгүй шаардлагатай шуурхай эрэн сурвалжлах ба эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан бусад арга хэмжээг авах үүрэгтэй.

Мөн 123-р зүйл буюу хэрэг бүртгэх байгууллагын ажиллагаа нь гэмт хэргийн шинж байгаа бол хэрэг бүртгэх байгууллага эрүүгийн хэрэг үүсгэж, эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтыг удирдлага болгон, гэмт хэргийн ул мөрийг олж тогтоох ба хамгаалах талаар мөрдөн байцаалтын хойшлуулшгүй ажиллагаануудыг хийх үүнд: үзлэг, нэгжлэг хийх, шаардлагатай зүйлийг хураан авах, сэжигтэнг албадан саатуулах ба байцаах, хохирогч, гэрчийг байцаах, түүнчлэн яллагдагчаар татах тухай тогтоол гаргах ба ял сонсгохоос бусад энэ хуульд заасан мөрдөн байцаалтын ажиллагаануудыг хийнэ.

Хэрэг бүртгэх байгууллага, гэмт хэргийг илрүүлсэн ба түүнийг бүртгэж эхэлсэн тухайгаа нэн даруй прокурорт мэдэгдэнэ. Хэрэг бүртгэх байгууллага мөрдөн байцаалтын хойшлуулшгүй ажиллагаануудыг арван дөрвөн хоногийн дотор гүйцэтгэж, мөн хугацааны дотор хэргийг мөрдөн байцаагчид шилжүүлнэ. Гэмт хэргийг илрүүлэх ба хэрэгтэнг олох бололцоо байгаагүй хэргийг мөрдөн байцаагчид шилжүүлсний дараа хэрэг бүртгэх байгууллага нь мөрдөн байцаагчийн даалгавраар гэмт хэргийг илрүүлэх ба хэрэгтнийг олох талаар зайлшгүй шаардлагатай шуурхай

¹⁴⁹ БНМАУ хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл 1963он. БНМАУ-ын хуулиуд 1. УБ., 180 дахь тал

эрэн сурвалжлах ажиллагаануудыг үргэлжлэн хийх үүрэгтэй. Гүйцэтгэсэн ажлынхаа дүнг тухай бүр мөрдөн байцаагчид мэдэгдэж байна.

Урьдчилсан мөрдөн байцаалт явуулах байгууллага 125-р зүйлд. Эрүүгийн хэрэгт урьдчилсан мөрдөн байцаалтыг прокурорын ба цагдан сэргийлэх байгууллагын мөрдөн байцаагч, түүнчлэн Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны улсыг аюулаас хамгаалах байгууллагын мөрдөн байцаагч явуулна. Үүнд:

БНМАУ-ын эрүүгийн хуулийн 58-60, 96-105, 107, 108, 136, 137, 143-145, 149, 150, 155, 176, 191-221-р зүйл, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1962 оны 12-р сарын 7-ны 204-р зарлигт заасан гэмт хэрэг, мөн шүүх, прокурор, өмгөөлөх байгууллагын ажилтны үйлдсэн гэмт хэрэгт урьдчилсан мөрдөн байцаалтыг прокурорын мөрдөн байцаагч, эрүүгийн хуулийн 45-57, 61-62-р зүйлд заасан гэмт хэрэгт урьдчилсан мөрдөн байцаалтыг НАХ Яамны улсыг аюулаас хамгаалах байгууллагын мөрдөн байцаагч, эрүүгийн хуулийн дээр дурдсанаас бусад зүйлд заасан гэмт хэрэгт урьдчилсан мөрдөн байцаалтыг улсын цагдан сэргийлэх байгууллагын мөрдөн байцаагч тус тус явуулна. Харин эрүүгийн хуулийн 63, 64-р зүйлд заасан гэмт хэрэгт урьдчилсан мөрдөн байцаалт явуулахдаа улс олон нийтийн хөрөнгийг хулгайлсан, дээрэмдсэн хэрэг, мөн цагдан сэргийлэх байгууллагын эрэн сурвалжлах, шуурхай албаны ажлын үр дүнд илэрсэн ашиглан шамшигдуулсан хэрэгт цагдан сэргийлэх байгууллагын мөрдөн байцаагч, улс олон нийтийн хөрөнгийг ашиглан шамшигдуулсан нь дээрхээс бусад байдлаар илэрсэн бол урьдчилсан мөрдөн байцаалтыг прокурорын мөрдөн байцаагч явуулна¹⁵⁰.

Хэрэг бүртгэх, урьдчилсан мөрдөн байцаалт явуулах ерөнхий нөхцлийн 135-р зүйл. Зарим даалгаварт. Хэрэг бүртгэгч буюу мөрдөн байцаагч өөр орон нутагт гүйцэтгэх шаардлагатай мөрдөн байцаалтын ба эрэн сурвалжлах зарим ажиллагааг өөрөө гүйцэтгэх буюу тухайн орон нутгийн хэрэг бүртгэх зохих байгууллага буюу мөрдөн байцаагчаар гүйцэтгүүлэхээр даалгах эрхтэй бөгөөд тэд нь тэрхүү даалгаврыг арав хоногийн дотор биелүүлэх үүрэгтэй. Урьдчилсан мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх үндэс ба хугацаа 192-р зүйлд. Урьдчилсан мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэхийн өмнө мөрдөн байцаагч яллагдагчийн байхгүйгээр гүйцэтгэж болох мөрдөн байцаалтын бүх ажиллагааг гүйцэтгэх, яллагдагчийг олж илрүүлэх буюу гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тогтоох бүх арга хэмжээг авах үүрэгтэй.

Уг хуулийн яллагдагчийг эрэн сурвалжлах буюу 193-р зүйлд яллагдагчийн байгаа газар мэдэгдэхгүй байвал мөрдөн байцаагч эрэн сурвалжлах шаардлагатай арга хэмжээг авна. Мөрдөн байцаагч эрэн сурвалжлах ажлыг гүйцэтгүүлэхээр цагдан сэргийлэх байгууллагад даалгах эрхтэй бөгөөд энэ тухай тусгай тогтоол гаргана.

Эрэн сурвалжлах явдлыг урьдчилсан мөрдөн байцаалтын үед буюу хэргийг түдгэлзүүлэхийн хамт зарлана. Энэ хуулийн 87, 94-р зүйлд заасан үндэс бүхий

¹⁵⁰ БНМАУ хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл 1963 он. БНМАУ-ын хуулиуд 1. УБ., 180-260 дахь тал

байвал мөрдөн байцаагч эрэн сурвалжлуулж байгаа этгээдийн хувьд прокурорын зөвшөөрөлтэйгээр цагдан хорихоор таслан сэргийлэх арга хэмжээ авч болно¹⁵¹.

Мөн Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1964 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 144 дүгээр зарлигаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн (154-р зүйлд), нутаг заагдсан этгээд оргох буюу нутаг зайлуулагдсан этгээд дур зоргоороо эргэж ирэх буюу засан хүмүүжүүлэх ажлаас зайлсхийх гэмт хэргүүдийг нэмж хамааруулсан байна

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /1994.03.28/

1992 онд шинэ Үндсэн хууль батлан мөрдүүлсний дараа 1994 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар ЭБШХ-д зарчмын, томоохон нэмэлт өөрчлөлт оруулжээ. Энэ хуулийн 193-р зүйлд. Сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжлах

Сэжигтэн, яллагдагч оргон зайлсан байвал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрэн сурвалжлах шаардлагатай арга хэмжээг авна. Мөрдөн байцаагч эрэн сурвалжлах ажлыг гүйцэтгүүлэхээр цагдаагийн байгууллагад даалгах эрхтэй бөгөөд энэ тухай тогтоол гаргана.

Эрэн сурвалжлах явдлыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед буюу хэргийг түдгэлзүүлэхийн хамт зарлана. Энэ хуулийн 87, 94 дүгээр зүйлд заасан үндэслэл байвал мөрдөн байцаагч эрэн сурвалжилж байгаа этгээдийг прокурорын зөвшөөрөлтэйгээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно¹⁵².

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох арга хэмжээ 94-р зүйлд. Энэ хуулийн 192 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан тохиолдолд хэргийг түдгэлзүүлсний дараа мөрдөн байцаах байгууллага өөрөө буюу цагдаагийн болон хэрэг бүртгэх бусад байгууллагатай хамтран гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох арга хэмжээ авах үүрэгтэй¹⁵³ хэмээн хамтын ажиллагааг хуульчилсан байна.

Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль /2002.01.10/

ЭБШ хуулийг 1 дүгээр сарын 10-ны өдөр тус тус баталж мөн оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн. Шинэчлэн найруулж 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн Эрүүгийн байцаан шийтгэх хууль нь дотоод, гадаадын эрдэмтэн судлаачдын дүгнэснээр хэргийн бодит үнэнийг тогтоох, талуудын байцаан шийтгэх ажиллагаанд оролцох үүргийн бодит-практик тэнцвэрт байдлыг хангаж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг эрх зүйт төрийн үзэлд тохируулж олон улсын жишигт нийцсэн хууль болжээ.

Хэрэг бүртгэгч мөрдөн байцаагчийн эрх үүрэг буюу энэ хуулийн 28.2.15. өөр орон нутагт байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрэн сурвалжлах, түүнчлэн гүйцэтгэх тодорхой ажиллагаа явуулах шаардлагатай бол энэ тухай даалгаврыг бичгээр гаргах ба түүнийг хүлээн авсан

¹⁵¹ Б. Баярсайхан, Ч.Дашням, Д.Батжаргал, Ж.Энхнасан, Г.Оюунболд, Д.Сумъяацэрэн. Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал.2012он. 133-151 дахь тал

¹⁵² Төрийн мэдээлэл.УБ 1994 он.№5

¹⁵³ Б. Баярсайхан, Ч.Дашням, Д.Батжаргал, Ж.Энхнасан, Г.Оюунболд, Д.Сумъяацэрэн. Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал.2012он. 339-340 дахь тал

хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага заасан хугацаанд заавал биелүүлж хариуг цугларсан нотлох баримтын хамтаар хүргүүлэх гэж үүрэг болгосон байна. Мөн хуулийн 29.1.1. хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны даргын эрх хэмжээнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах замаар гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох талаар шуурхай зохицуулалт хийнэ гэж тусгажээ.

Энэ хуулийн 205.2.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэхийн өмнө хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтэн, яллагдагчийн байхгүйд гүйцэтгэж болох бүх ажиллагааг явуулах, гэмт хэрэг үйлдсэн болон оргон зайлсан этгээдийг олж илрүүлэх бүх арга хэмжээг авах үүрэгтэй. Энэ хуулийн 206 дугаар зүйлд Сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжлах гэж хуульчилжээ. 206.1-д Сэжигтэн, яллагдагч оргон зайлсан бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрэн сурвалжлах арга хэмжээг авна.

206.2.Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор эрэн сурвалжлах ажлыг гүйцэтгүүлэхээр цагдаагийн байгууллагад даалгаж, энэ тухай тогтоол гаргана¹⁵⁴ гэж заажээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2017.05.18/

Энэ хууль нь эрэн сурвалжлах ажлын хувьд томоохон өөрчилт орсон ба тус хуульд эрх бүхий албан тушаалтанд үүрэг байхаас гадна арван хоёрдугаар бүлэгт тусгайлан бүлэг болгосон байна. Мөн хуулийн арван хоёрдугаар бүлэг Мөрдөгч дараахь хүн, хуулийн этгээд, эд зүйл, хөрөнгийг олох зорилгоор эрэн сурвалжлах ажиллагааг өөрийн санаачилгаар, эсхүл шүүхийн шийдвэр, прокурорын даалгавраар явуулна¹⁵⁵:

- 1.байгаа газар нь мэдэгдэхгүй байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний хариуцагч, гэрч;
- 2.оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч;
- 3.хулгайлагдсан, барьцаалагдсан хохирогч;
- 4.хэн болох нь тодорхойгүй цогцсыг тогтоох;
- 5.эмнэлгээс оргосон сэтгэцийн өвчтэй хүн;
- 6.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий эд зүйл, мал, амьтан, баримт бичиг, тээврийн хэрэгсэл.

Хэрэв өөр нутаг дэвсгэрт мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрэн сурвалжлах шаардлага гарвал энэ тухай даалгаврыг бичгээр хүргүүлэх ба түүнийг хүлээн авсан мөрдөн шалгах байгууллага даалгаврыг заасан хугацаанд биелүүлж, хариуг цугларсан нотлох баримтын хамтаар ирүүлэх;

Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эрэн сурвалжлах, мөрдөн шалгах ажиллагааг харьяаллын бус мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагаар хийлгэх шаардлага гарвал мөрдөгч энэ тухай саналаа прокурорт гаргана. Прокурорын даалгаврыг хүлээн авсан тухайн мөрдөн шалгах ажиллагааг явуулах

¹⁵⁴ Төрийн мэдээлэл. УБ 2002 он.№6.

¹⁵⁵ Төрийн мэдээлэл. УБ 2017 он.№23

байгууллага даалгаврыг заасан хугацаанд биелүүлж, хариуг цугларсан нотлох баримтын хамт прокурорт хүргүүлнэ¹⁵⁶.

Эрэн сурвалжлах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага шүүх, прокурорын шийдвэрийн дагуу яллагдагч, шүүгдэгчийг эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулж, үр дүнг шүүх, прокуророос тогтоосон хугацаанд танилцуулна гэж тус тус хууль тогтоомжид тусгагдсан байна.

¹⁵⁶ Төрийн мэдээлэл. УБ 2017 он.№23

**ЦАГДААГИЙН ТАКТИК ТУСГАЙ БЭЛТГЭЛИЙН
ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ****УСАН ХӨӨРӨГТ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, БҮТЭЦ,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АШИГЛАХ АРГАЧЛАЛ, АНХААРАХ ЗАРИМ
АСУУДАЛ***Ш. Чулуун**Цагдаагийн сургуулийн Дотоодын цэргийн
тэнхимийн дэд профессор,
цагдаагийн дэд хурандаа*

Товч агуулга: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагаас усан хөөрөгт машиныг хэрхэн ашиглах аргачлал, анхаарах асуудал болон усан хөөрөгт машины бүтэц, онцлог, зохион байгуулалтын талаар авч үзсэн болно.

Түлхүүр үг: Усан хөөрөгт машин, багийн ахлагч, оператор, усан хөөрөгч, механик жолооч, техникч, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, эрх зүйн зохицуулалт

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон үед түүнийг албадан тараах болон хууль бусаар зохион байгуулж байгаа жагсаал цуглааныг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр албадан тараах үедээ олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх эрхтэй байна. Хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг хэрэглэх боломжтой хэрэгслийг олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл гэх ба үүнд дараах хэрэгсэл хамаарна.

1/ Олон хүнд нэг зэрэг нөлөөлөх нулимс асгаруулагч:

Хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг нөлөөлөх хамрын самсаа болон нулимсны булчирхайг цочроож нулимс ихээр гоожуулах хий, шингэн төлөв байдалтай бодисыг хэлнэ. /Гар бөмбөг, сум, утаа, шүршүүр хэлбэртэй байж болно./

2/ Олон хүнд нэг зэрэг нөлөөлөх амьсгал боогдүүлэгч:

Хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг нөлөөлөх амьсгалын замын эрхтнээр дамжин уушгинд хүрч ханиалгах, амьсгал, хоолой боох үйлчлэл үзүүлэх зориулалт бүхий шингэн болон хийн төлөв байдалтай бодисыг хэлнэ.

3/ Усан хөөрөг:

Усыг өндөр даралтаар хүчтэй цацах төхөөрөмжийг¹⁵⁷ хэлнэ.

4/ Утаан хөшиг үүсгэгч:

¹⁵⁷Цагдаагийн албаны тухай хуулийн 53-р зүйлийн 53.1 дэх заалт

Үзэгдэх орчныг хязгаарлах зорилгоор утаан хөшиг үүсгэх бодис /Гар бөмбөг, сум, утаа, шүршүүр хэлбэртэй байж болно./

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг Цагдаагийн албаны тухай хуулинд¹⁵⁸ дараах тохиолдолд хэрэглэхээр зааж өгчээ. Үүнийг тодотгон авч үзвэл:

- Цагдаагийн алба хаагч болон бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар бүлэглэн довтолсон, эсэргүүцсэн;
- Төрийн тусгай хамгаалалтад байгаа, эсхүл бусад байгууллагын хамгаалалтад байгаа хүн, объектод бүлэглэн халдсан, халдахыг завдсан;
- Бусдын орон байр, эзэмшил газрыг бүлэглэн эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх;
- Хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох гэмт хэргийг бүлэглэн үйлдэж байгааг таслан зогсоох, баривчлах;
- Галт зэвсэг, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн бүлэг зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн;
- Нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг, эсхүл нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хүч хэрэглэсэн жагсаал цуглааныг албадан тараах;
- Бүлэглэн оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг баривчлах;
- Хорих анги, цагдан хорих байранд эмх замбараагүй байдал үүссэн үед гэж тус тус нарийвчлан тусгажээ.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэрийг цагдаагийн байгууллагын дарга, түүний эрх олгосноор тухайн ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан¹⁵⁹ гаргаж дараах журмаар хэрэгжүүлнэ.

- Шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан хэрэглэх тусгай хэрэгслийн төрөл, тоо хэмжээ, хэрэглэх хүрээ, дэс дараалал, эхлэх, дуусгах шийдвэрийг гаргах;
- Цагдаагийн алба хаагчийг хамгаалах тусгай хэрэгслээр хангах;
- Цаг хугацааны хувьд боломжтой бол прокурорт урьдчилан мэдэгдэх;
- Эмнэлгийн болон мэргэжлийн байгууллагад мэдэгдэх;
- Уг хэрэгслийн нөлөөлөх бүсэд байгаа жирэмсэн эмэгтэй, насанд хүрээгүй этгээдийг тухайн бүсээс холдох талаар тусгай хэрэгсэл хэрэглэхээс өмнө анхааруулах;
- Боломжтой бол тухайн тусгай хэрэгслийн үйлчлэх нөлөөллийн талаар анхааруулах;

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэр гаргадаг албан тушаалтан нь дараах үүргийг хүлээнэ.¹⁶⁰ Үүнд:

¹⁵⁸Цагдаагийн албаны тухай хуулийн 54-р зүйлийн 54.2 дахь заалт

¹⁵⁹Цагдаагийн албаны тухай хуулийн 54-р зүйлийн 54.1 дэх заалт

¹⁶⁰Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалын 1-р хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 4-р

- Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх хуульд заасан үндэслэл байгаа эсэхийг магадлан, тусгай хэрэгсэл хэрэглэх зорилгыг тодорхойлох
- Цаг агаарын байдал, салхины чиглэлийг харгалзан хэрэглэх тусгай хэрэгслийн төрөл, тоо хэмжээ, хүрээ, дэс дараа, тактикийг тогтоох
- Тухайн орчинд байгаа хүмүүст амьсгал боогдуулах, нулимс асгаруулагч, усан хөөрөг зэрэг олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэх гэж байгааг сануулж, тарж явахыг анхааруулах
- Алба хаагчдыг хамгаалах тусгай хэрэгслээр хангаж олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсэн бүсэд оруулах
- Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсэн тухай прокурорт мэдэгдэж, бичгээр танилцуулах
- Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийн үйлчлэлээр нүд аргаж өвдөх, нулимс асгарах, амьсгаа давхцах шинж тэмдэг илэрч, амьсгалын замын багтраа өвчин, зүрхний эмгэг өвчтэй хүнд онцгой нөлөөлөх тул эмнэлгийн байгууллагын туслалцааг нэн даруй авах

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх тухай урьдчилан анхааруулахдаа тодорхой хугацаа зааж, чанга яригчаар зарлах зэрэг боломжтой аргыг хэрэглэнэ. Урьдчилан анхааруулснаас хойш заасан хугацаанд үйлдлээ зогсоогоогүй бол тусгай хэрэгсэл хэрэглэнэ.

Олон хүнд зэрэг нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсний дараа хэрэглэх шийдвэрийг гаргасан цагдаагийн байгууллагын дарга, эсвэл түүний эрх олгосноор тухайн ажиллагааг удирдсан албан тушаалтан нь холбогдох байгууллагатай хамтран дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.¹⁶¹ Үүнд:

- Хордсон хүн, амьтан, тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон аюултай бодис алдагдах, гал түймэр гарах эх үүсвэр байгаа эсэхийг шалгаж, аюулгүй болгох;
- Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах;
- Орчныг ариутгах арга хэмжээ авах талаар холбогдох байгууллагад мэдэгдэх;
- Тусгай хэрэгслийн үйлчлэл дуусах, эсхүл үүссэн аюултай нөхцөл арилах хүртэл тухайн орчинд эргүүл, хамгаалалт гаргаж, зөвлөгөө, сануулга өгөх.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсэн үндэслэл, явц, үр дүн, хүний эрүүл мэндэд гарсан өөрчлөлт, эмнэлгийн тусламж үзүүлэх арга хэмжээ авсан тухай дэлгэрэнгүй илтгэх хуудсыг нэн даруй бичиж шууд захирах даргад, шууд захирах дарга нь дээд шатны байгууллагын даргад танилцуулсан байна.¹⁶²

Усан хөөрөгт тээврийн хэрэгсэл

хэсгийн 4.2 дахь заалт

¹⁶¹Цагдаагийн албаны тухай хуулийн 54-р зүйлийн 54.6 дахь заалт

¹⁶²“Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл” нэг сэдэвт бүтээл 2019 он 81-р тал

Усан хөөрөгт тээврийн хэрэгслийг холбогдох албаны даргын тушаалаар томилогдсон дараах 5 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллуулна.¹⁶³

- Багийн ахлагч: Шуурхай удирдлагын штабын даргын шийдвэр, тусгай хэрэгсэл хэрэглэх бүлгийн даргын удирдлагад ажиллаж, багийн үйл ажиллагааг удирдана.
- Усан хөөрөгч: Усан хөөргийн төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалтыг хариуцна.
- Оператор: Дуу, дүрс бичлэгийн төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалтыг хариуцна.
- Техникч: Нулимс асгаруулагч, будагч бодис, усаар цэнэглэх, усны хоолойг холбох, салгах болон нөөц жолоочийн үүрэг гүйцэтгэнэ.
- Механик-жолооч: Машины техникийн аюулгүй ажиллагааг ханган ажиллана гэж тус тус заасан байна.

Багийн гишүүд бусад гишүүдийн үүргийг орлон гүйцэтгэх ур чадварыг эзэмшиж багаар ажиллах чадвартай байна. Багийн гишүүд болон нөөц хүчийг сард нэгээс доошгүй удаа сургалт, дадлага хийлгэнэ.

Усан хөөрөгт тээврийн хэрэгслийн бүхээгт багийн гишүүдээс өөр хүн оруулахыг хориглоно. Усан хөөрөгт тээврийн хэрэгслийг хамгаалалтын бүсийн дотор, гадна талд байрлуулж хэрэглэнэ. Усан хөөргийг жагсаал, цуглааны үед ашиглах тохиолдолд техникийн бүрэн бүтэн байдал, найдвартай ажиллагааг хангах үүднээс хамгаалалтын тусгай бүлэг томилж ажиллуулна.

Усан хөөргийг +1°C хэмээс дээш дулаантай тохиолдолд ашиглана. Энэ нь усан хөөргөөр тоногдосон тээврийн хэрэгслийн бусад төхөөрөмжийг ашиглахад хамаарахгүй. Усан хөөрөгт тээврийн хэрэгслийн тасралтгүй ажиллагааг хангах ус тээвэрлэгч нөөц тээврийн хэрэгслийг цагдаагийн хамгаалалтад бэлэн байрлуулсан байна.¹⁶⁴

Усан хөөрөгт тээврийн хэрэгсэл ашиглаж байгаа газарт ойр байгаа усны эх үүсвэрийг ашиглаж болно. Усан хөөрөгт хуягласан тээврийн хэрэгслийн түрэх төхөөрөмжийг зам чөлөөлөх, учрах саадыг арилгах, гудамж гаргах болон бусад зориулалтаар ашиглаж болно.

Усан хөөрөгт тээврийн хэрэгсэл, түүний бүлгийн ахлагч болон операторыг тус бүрд нь хэт богино долгионы радио станцаар хангасан байна. Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, будагчийг агаарын температур -10°C хэмээс дулаан үед хэрэглэнэ¹⁶⁵ гэжээ.

¹⁶³“Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл” нэг сэдэвт бүтээл 2019 он 123-р тал

¹⁶⁴Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалын 1-р хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 4.13 дахь хэсэг

¹⁶⁵Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалын 1-р хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 4.17 дахь хэсэг

Усан хөөрөгт тээврийн хэрэгслийн үзүүлэлт, хүчин чадал

“Jinjin”-усан буу нь (JRS-6500) хөнөөлт бус өндөр үр дүнтэй нь батлагдсан нийтийн эмх замбараагүй байдал, хууль бус жагсаал, цуглааны үед ашиглах төхөөрөмж юм.



Энэ авто машин нь хамгаалалтын болон шийдвэрлэх үед тусламж үзүүлэх зориулалттай юм. Усан буу нь өндөр даралтат насосоор тоноглогдсон ба засвар үйлчилгээ хийх үед хялбар салгагдана.

Дээврийн буунууд нь хэвтээ чиглэлд 340 градусаар, босоо чиглэлд 80 градусаар дээд тал нь 60 м дотор хүчтэй буудна. Кабин дотор 5 хүний

багтаамжтай ба бүх тоног төхөөрөмжийг тэд ажиллуулах бололцоотой.

Онцлог. Өндөр даралтад усан буу нь минутанд 2000 л/мин 14 бар-ын даралттайгаар шахах чадвартай. Уг машин нь дээрээ 6, баруун талдаа 3, зүүн талдаа 3, доод талдаа 4 ус болон бодис гаргах цорготой байна.

Кабин дээр байрлах буу нь автомат удирдлагаар дурын зүгт буудах чадвартай бөгөөд 6500 л багтаамжтай усны савыг түргэн хугацаанд дүүргэх ба юүлэх зориулалтаар тоноглогдсон юм.

Олон талын зориулалт бүхий уг автомашиныг бослого тараах, цэвэрлэгээ хийх, энгийн ард иргэдэд усны тусламж үзүүлэх зорилгоор хэрэглэж болох бөгөөд химийн /хөөс, нулимс асгаруулагч, будаг/ цацах боломжтой юм.

Бүрэн тоноглогдсон хяналтын самбараар хөдөлгүүрийн байдал, нэмэлт хөдөлгүүрийг хянахаас гадна бүх буу болон хавхлагуудыг хянах боломжтойгоос гадна түлхүүр багаж хийж болохуйц цоожтой хайрцагнуудтай.

Кабин дээрхи бууны хамт өндөр хүчин чадал бүхий гэрлээр давхар тоноглогдсон байдаг.

Ерөнхий тодорхойлолт¹⁶⁶

Тэнхлэг хоорондын зай	4650 мм
Нийт урт	7980 мм
Өргөн	2560 мм

¹⁶⁶ ЦЕГ-ын автобаазын инженер техникийн албаны 2009 онд JRC-6500B хуягт, усан хөөрөгний авто машин хүлээн авсан, шалгасан тухай үзлэгийн тэмдэглэл

Өндөр	3760 мм
Газраас хамгийн бага өргөгдсөн хэсэг	260 мм

Хүндийн жин

Цэвэр жин	9950 кг
Багийн гишүүд	325 /65*5/
Нэмэлт ачаа	6950 кг
	/ус, будаг, хөөс, хий/
Нийт жин	17225 кг

Өнгө

Чулуун саарал /stone gray/

Арал

Үйлдвэр	Tato Daewoo motor
Жолооны хүрд	Зөл талдаа
Хөдөлгүүр	DE 12TIS
	дизель, турботой,
	6 цилиндртэй,
	усан хөргөлттэй
Дээд хүч	320hp/2100rpm
Дээд эргүүлэх хүч	135 кг. м/1260rpm
Хөдөлгүүрийн багтаамж	11051cc

Гүйцэтгэл

Дээд хурд	99 км/ц
Хамгийн бага эргэх радиус	8.5 м
Хүч дамжуулга	Механик
	/урагш 6 ухрах 1/
Урд тэнхлэг/даац/	6500 кг
Хойд тэнхлэг/даац/	11500 кг
Дугуй	6 ш /11.00-20-16 pr
Обуд	7,5v*20
Хүрдний механизм	Гидро
Тормоз	Хийн
Түлшний савны багтаамж	200 л цоожтой, галаас хамгаалагдсан

Цахилгаан систем

Аккумулятор	12v-150amp/h*2
Динам	24v-60a
Стартер	24v-660kw

Кабин

Давхар кабинтай халдлагаас сэргийлж цонхыг торлосон хажуу болон дээд талыг хатуу гангаар хийсэн.

Камерын систем

Камер	Дижитал 220*22
Дэлгэц	7 инч өнгөт дэлгэц
DVR систем	500mb HD – тэй бичлэг хийх Арыг харах DSP 7 инч өнгөт дэлгэц
Р.А систем	Чанга яригч болон дуут дохиотой
Кабины хөргөлт	А/С хөргөлт
Аюулгүйн гарц	Дээрээ 2 хаалгатай

Усны сав

Материал	Ган төмөр /sts304/ 4.0мм
Гагнуур	Аргон болон хийн
Багтаамж	6500 л усны цалгилтаас хамгаалагдсан тоноглолтой

Цэвэрлэх зориулалт бүхий нүхтэй

Зөөлөвч	Резин ба төмөр
Савны нүх	500мм
Усны түвшин хэмжигч	Датчик болон харж болохуйц
Ус дүүргэх холболт	Эрвээхэй хавхлага 2-1/2”
Сорох холболт	Эрвээхэй хавхлага 4”
Ус гаргах хоолой	Бөмбөгөн хаалт 2”
Усны сав дүүргэх	Гол цөөрөм нуур

Хөөсний сав

Багтаамж	150л
Материал	Ган төмөр /sts316/ 3 мм
Хөөс дүүргэлт	Савны амсар хүртэл
Хөөс юүлэх хавхлага	Бөмбөгөн хавхлага $\frac{3}{4}$
Хөөсний түвшин үзэх	Датчик болон харж болохуйц

Нулимс асгаруулагчийн сав

Багтаамж	150 л
Материал	Ган төмөр /sts316/ 3 мм
Хөөс дүүргэлт	Савны амсар хүртэл
Хөөс юүлэх хавхлага	Бөмбөгөн хавхлага $\frac{3}{4}$

Хөөсний түвшин үзэх

Датчик болон харж болохуйц

Будагны сав

Багтаамж

150 л

Материал

Ган төмөр /sts316/ 3 мм

Хөөс дүүргэлт

Савны амсар хүртэл

Хөөс юүлэх хавхлага

Бөмбөгөн хавхлага

3/4

Хөөсний түвшин үзэх

Датчик болон харж болохуйц

Төвөөс зугтаах насосны тодорхойлолт

/Centrifugal pump specification/

Төрөл

2 шаталбарт турбинтэй насос

Гүйцэтгэл

2650 л/мин8,5 bar

2000 л/мин 14 bar

Материал

Хайлш гантимөр хүрэл

Эргэх чиглэл

Цагийн зүүний дагуу

Насосны систем

4 тасалгаа бүхий вакуум

Ажиллах нөхцөл

Араагаар /gear box/

Хяналт

Цахилгаан

Хүчдэл

24 v

Насосны хөдөлгүүр

Төрөл

4 циклийн турботой
усан хөргөлттэй Дизель

Цилиндер

4

Багтаамж

3907 cc

Гарах хүч

125 hp/2600rpm

Дээд эргэлтийн хүч

40кг.м/1800rpm

Эргэх чиглэл

Цагийн зүүний эсрэг

Стартер

24v-5kw

Хэрэглээ

24v

Хөөс, нулимс аргаруулагч, будагны системийн хэсэг

Төрөл

Цорго хэсэг

Материал

Ni-Cr

Гүйцэтгэл

410-1050 л/мин 5 bar

Ашиглалтын систем

автомат

Бууны систем

Кабин дээрхи буу/баруун тал/

LP-2-1/2”/65A/

Цорго /диаметр/

29мм

Цацах хүрээ

40м-60м

Эргэх хүрээ	Хэвтээ 340 градус босоо - 45 аас +80 градус
Байрлал	Кабин дээр
Удирдлага	Хяналтын самбараас
Буфер дээрхи буу	
Гүйцэтгэл	1000 л/мин 5 bar
Цацах хүрээ	30м-40м
Эргэх хүрээ	Хэвтээ 180% босоо 40-с +80%
Хяналт	Хяналтын самбараас
Хэвтээ буу	
Гүйцэтгэл	400 л/мин 5bar
Цацах хүрээ	20 м
Эргэх хүрээ	45 градус
Бууны тоо	2 ш
Байрлал	Хөдөлгүүрийн баруун, зүүн талд
Хамгаалалтын цорго	
Цоргоны тоо	дээр 6 ш, доор 4 ш
Гүйцэтгэл	30 л/мин 5 bar
Материал	Хүрэл

Уг усан хөөрөгт тээврийн хэрэгсэл нь хуяглагдсан, тусгай тоноглолтой, дээд хэсэгт үндсэн 2 ширхэг шүршигч буутайгаас гадна урд гуперийн хэсэгт шүршигч буугаар тоноглогдсон, 2 талын хажуу болон ар талдаа, мөн дээд доод хэсэгтээ 4 усаар шүршигч клапантай байдаг.

Кабин дээр нь 150 литрийн багтаамжтай 3 ширхэг савтай бөгөөд тус савнуудад нулимс асгаруулагч, хөөс, будаг холигч элементийг хийхэд усанд өөрөө найруулагддаг, усны ёмкост нь зэвэрдэггүй гангаар хийгдсэн бөгөөд 6.5 тонн усны багтаамжтай юм.

Хөдөлгүүр нь D6AV цуваа цилиндртэй, турбин дизель хөдөлгүүртэй. Шатахууны сав нь 200 литрийн багтаамжтай бөгөөд сайн түгжээ бүхий банк нь далд байрлахын зэрэгцээ галын аюулаас бүрэн хамгаалагдсан.

Кабин нь давхар кабинтайгаас гадна сайжруулсан төмрөөр хамгаалалт хийгдсэн, салхины болон хажуугийн шилнүүдийг торон хаалтаар хамгаалж тоноглогдсон байна.

Кабиндаа жолооч, хажуугийн туслах, ардаа 2 суудалтай, ТВ системтэй ба камер дүрс гаргах дэлгэц, дүрс бичлэг 24 цагийн турш хийгдэх боломжтой гэжээ.¹⁶⁷

¹⁶⁷ЦЕГ-ын автобаазын инженер техникийн албаны 2009 онд JRC-6500B хуягт, усан хөөрөгний авто машин хүлээн авсан, шалгасан тухай үзлэгийн тэмдэглэл

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед усан хөөрөгт тээврийн хэрэгсэл ашиглах арга зүй

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь нийтийн хамарсан эмх замбараагүй байдал бий болсон үед гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд хуулинд заасан үндэслэл журмын дагуу олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх эрхтэй байна.

Олныг хамарсан үймээн самуун, эвдэн бусниулах, галдан шатаах, эд хөрөнгө устгах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх буюу төрийн төлөөлөгчийг зэвсэглэн эсэргүүцэх үйл ажиллагаа нөхцөл байдлыг нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гэнэ.¹⁶⁸

Цагдаагийн албан хаагч нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлэх явцад хууль бус жагсаал цуглааныг албадан тараах, бүлэглэн танхайрах явдлыг таслан зогсоох, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх нөхцөл байдал бий болох, хориотой арга хэрэгсэл ашиглан төрийн төлөөлөгчийн тавьсан шаардлагыг зэвсэглэн эсэргүүцэх зэрэгт ердийн арга хэрэгсэл ашиглан тодорхой үр дүнд хүрээгүй тохиолдолд хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг зохих журмын дагуу тухайн нөхцөл байдалд ялгамжтай байдлаар хэрэглэдэг байна.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэхийн өмнө нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагын үнэлгээ хийж бодит үндэслэл байгаа эсэхийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай.

Түүнчлэн хүрээлэн байгаа орчин, эрсдэл бий болох нөхцөл байдлыг урьдчилан тодорхойлох, хэрэглэсний дараа гарч болох үр дагаварыг тооцоолон төлөвлөгөө гарган ажиллана.

Цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр байгуулагдсан шуурхай удирдлагын штабын даргын зөвшөөрөлгүйгээр жагсаал цуглааныг албадан тараах, нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын үед галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал идэвхижиж цагдаагийн байгууллага, алба хаагчийн тавьсан шаардлага, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зохих үр дүнгээ өгөөгүй, хяналтаас гарах нөхцөл бүрдсэн тохиолдолд үймээнд оролцогчдын үйлдлийг цаашид даамжируулахгүй, учирч болох хор уршгийг нэмэгдүүлэхгүй байлгах, тэдний хууль бус үйлдлийг таслан зогсооход усан хөөрөгт машин ихээхэн чухал үүрэг гүйцэтгэнэ.

Усан хөөрөгт тээврийн хэрэгслийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалд¹⁶⁹ заасны дагуу +1

¹⁶⁸2017 оны 12-р сарын 28-ны өдөр шинэчлэн баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код-504 “Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам”-ын 504-ийн 2 дахь хэсэг

¹⁶⁹Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалын 1-р хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”

хэмээс дээш дулаан үед ажиллуулах бөгөөд ЦЕГ-ын даргын тушаалаар байгуулагдсан “Шуурхай удирдлагын штаб”-аас өгсөн үүрэг, чиглэл, захирамж, шийдвэрийн дагуу ажиллагаанд орно.

Уг усан хөөрөгт тээврийн хэрэгслийг ажиллагаанд оруулах зорилго нь нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох ажиллагаанд оролцож буй алба хаагч, бүлгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, нийтийг хамарсан эмх замбараагүй байдалд оролцогч этгээдүүдийн хүчийг сарниан бутаргах, тарамдуулах, түүнчлэн Шуурхай удирдлагын штабын дэргэдэх түрэн гаргах, дайчлан баривчлах бүлгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг тусалцаа үзүүлэхэд чиглэгдсэн байна.

Автомашиньг хэв журмын хамгаалалтанд зогсож байгаа цагдаагийн алба хаагчдын ар талд байрлуулж, жагсаал цуглаан болон эмх замбараагүй байдал үүсгэгчдийн бөөгнөрөл үүсч, нягтарсан хэсэг рүү дээврийн үндсэн бууг ашиглан 14-өөс дээш “bag”-ын даралтаар шүршиж, агшин зуур тараах ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

Түүнчлэн эмх замбараагүй байдал үүсгэж, цагдаагийн алба хаагчид руу дайрч, довтолж буй бүлэг этгээдүүдийн урд болон хажуу жигүүрээс нь усаар шүршиж, тэдний үйлдлийг сарниулж, хүчийг тарамдуулах арга хэмжээг тухайн нөхцөл байдлыг үнэлэн ажиллагааг удирдаж байгаа даргын шийдвэрээр түргэн шуурхай хийж гүйцэтгэнэ.

Гэхдээ ажиллагаанд оролцож байгаа бусад бүлгүүдийн үйл ажиллагаатай нарийн нягт харилцан уялдаатайгаар хэрэглэвэл үр дүнд хүрнэ. Мөн эмх замбараагүй байдлын гол төв хэсэг рүү хүчтэй даралттай усаар шүршиж тараах бөгөөд сарнисан хэсгүүдийн хойноос дагаж шүрших байдлаар тэдний үйл ажиллагааг улам бүр тарамдуулах, улмаар дайчлан баривчлах, түрэн гарах бүлгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллана.

Гэхдээ усан хөөрөгт тээврийн хэрэгсэл усаа хурдан хугацаанд шахдаг учир нөөц усны машинууд байнгын бэлэн байдалд байж, түргэн хугацаанд шуурхай цэнэглэж, дараагийн ажиллагаанд орох нөхцөл боломжийг бүрдүүлж өгөх хэрэгтэй юм. Усан хөөрөгт тээврийн хэрэгслийг дараагийн ажиллагаанд хэрхэн шилжих үүрэг даалгаврыг гагцхүү шуурхай удирдлагын штабаас өгөх учир бүлгийн дарга болон гишүүд үүрэг, чиглэл иртэл бие даан ямар нэг ажиллагаа явуулахыг хориглоно.

Түрэн гаргах бүлгийн үүрэг бол нийтийг хамарсан эмх замбараагүй байдалд оролцогсдыг голомтоос түрэн гаргах, тараах, үйл ажиллагааг нь тарамдуулах, тараах явдал юм. Тухайн эмх замбараагүй байдал гарсан бүс, нутаг дэвсгэрийн байршил, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, тухайн үеийн цаг агаарын байдлаас хамаарч тусгай хэрэгсэл хэрэглэх бүлэгт шуурхай удирдлагын штабаас өгсөн шийдвэрийн дагуу усан хөөрөгт тээврийн хэрэгслийг ашиглана.¹⁷⁰

Шуурхай удирдлагын штабаас шийдвэр гармагц тусгай хэрэгсэл хэрэглэх бүлгийн дарга усан хөөрөгт тээврийн хэрэгслийг ашиглан эмх замбараагүй байдлын

¹⁷⁰“Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл” нэг сэдэвт бүтээл 2019 он 129-р тал

нягтарсан цөм хэсэг рүү шүршилт хийж, тэдний хүчийг тарамдуулах, үйл ажиллагааг нь сарниулсны дараа түрэн гаргах бүлэг эхэлж орон дараа нь татан гаргаж, салган тусгаарлах бүлэг ажиллагаанд орж тэднийг тараах ажиллагааг гардан гүйцэтгэнэ.

